МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ

Эрхэмсэг хатагтай, ноёд оо!

Монголбанкны өмнө тулгамдаж байсан 2010 оны үндсэн зорилт нь зээлийн тасалдлыг арилгаж, эдийн засгийн өсөлтийг сэргээхэд чиглэгдэж байв. Монголбанк, Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтран эдийн засгийг тогтворжуулах "Стэнд-бай" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэв. 2010 онд ДНБ 6.1 хувиар, М2 мөнгө 62.5 хувиар, зээлийн өрийн үлдэгдэл 23 хувиар тус тус өссөн нь эдийн засаг хямралаас бүрэн гарсныг илтгэж байна.

Инфляци хурдацтай нэмэгдэж байсан 2010 оны эхний хагаст Монголбанк 5 дугаар сард бодлогын хүүгээ 11 хувьд хүргэн нэмэгдүүлэхийн зэрэгцээ ТБҮЦ-ны арилжаанд хүүний интервалтай арилжааны хэлбэрийг нэвтрүүлэн мөнгөний бодлогыг чангатгасны үр дүнд үнийн өсөлтийн хөөрөгдөл саарч оны эцэст инфляци 13.0 хувьтай гарлаа. Үүний 5.9 нэгж хувийг махны үнийн өсөлт дангаараа бүрдүүлсэн байна.

Хувийн секторын санхүүжилтийн гол эх үүсвэр нь банкны зээл хэвээрээ байна. 2010 онд олгосон зээл 42 хувиар, зээлийн өрийн үлдэгдэл 23 хувиар өссөн нь хувийн секторын өсөлтийг хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Олны анхаарлын төвд байнга байдаг жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын зээлийн өрийн үлдэгдэл 625 гаруй тэрбум төгрөгт хүрч 30 орчим хувиар өссөн бол иргэдийн орон сууцны зээлийн өрийн үлдэгдэл 363 тэрбум төгрөгт хүрч 48.7 хувиар өссөн байна.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлого баримтлан ажиллав. Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш оны эхнээс 13 хувиар чангарав. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2010 онд 82.6 хувиар нэмэгдэж 2.1 тэрбум ам.долларт хүрлээ. Цахим систем нэвтрүүлснээр банк хоорондын гадаад валютын арилжааг хялбарчлах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх өргөн боломж нээгдлээ. Түүнчлэн Монголбанк валютын арилжаанд санхүүгийн үүсмэл хэрэгслийг (своп, форвард) нэвтрүүлсэн нь ханшийн эрсдэлийг бууруулах, төгрөгийн спот захын дарамтыг сулруулах үндсийг бүрдүүлэв.

"Банкны тухай" хууль 2010 онд шинэчлэгдэн батлагдаж, холбогдох бусад журамд өөрчлөлт орсноор банкны системийн эрх зүйн орчин улам боловсронгуй боллоо. Банкны салбарын нийт актив өмнөх оноос 41.2 хувиар, татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн хэмжээ 33.9 хувиар тус тус өсчээ. 2010 онд нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 20.4 хувиар, хадгаламжийн хэмжээ 47.1 хувиар нэмэгдсэн нь иргэдийн банкинд итгэх итгэл сайжирсныг илтгэж байна. Банкуудын хөрвөх чадвартай активын хэмжээ нэмэгдснээр төлбөр түргэн гүйцэтгэх чадвар эрс сайжирлаа. Нийт чанаргүй зээл 2010 оны эцэст 11.5 хувьд хүрч буурав. Банкуудын ашигт ажиллагаа сайжирч, өөрийн хөрөнгө нэмэгдэж, чанаргүй зээлийн хэмжээ буурснаар банкны салбарын эрсдэл даах чадвар дээшлэв.

Монголбанк 2010 онд арилжааны банкуудтай хамтран “Нэг карт-Нэгдсэн сүлжээ” үйлчилгээг Монгол Улсын иргэн бүрт хүргэж эхэллээ. Монгол Улсын карт эзэмшигч бүр нийт 9 банкны 347 ширхэг АТМ төхөөрөмж, 4418 ширхэг ПОС терминал, 1576 ширхэг ПОБ терминалаар төлбөр тооцоогоо 24 цагийн турш тасралтгүй гүйцэтгэж байна.

Монголбанкны өмнө 2011 онд инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх, эдийн засгийн хямралыг сөрөх чадавхийг бий болгох замаар дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндсэн зорилт тавигдаж байна.

Монголбанк банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх, үйл ажиллагааных нь нээлттэй, ил тод байдлыг хангуулах, хяналт шалгалтыг цаашид сайжруулан, зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн банкны салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх чиглэлд тодорхой арга хэмжээнүүд авна. Мөн хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, хөрөнгө оруулалтын банкны эрх зүйн орчинг бүрдүүлэх болно.

Монголбанк төлбөрийн картын үйлчилгээг нэгдсэн нэг гарцтай болох талаар “Виза интернэшнл”, “Чайна юнион пэй” (CUP) зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллаж эхлээд байна. Ингэснээр Монгол Улсын төлбөрийн картын үйлчилгээний шимтгэл буурах, банкуудын тус тусдаа төлдөг хураамжийн хэмжээ буурч төлбөрийн картаар өөрийн орондоо төдийгүй гишүүн орнуудад төлбөр тооцоогоо саадгүй, хямд зардлаар гүйцэтгэх боломжтой болох юм.

Л.Пүрэвдорж
Монголбанкны Ерөнхийлөгч

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ.....4

1.1. Бодит эдийн засгийн хөгжил……....4
1.2. Төлбөрийн тэнцэл……10
1.3. Үнэ……..18
1.4. Засгийн газрын санхүү……..19
1.5. Хөрөнгийн захын хөгжил……21

2. МӨНГӨНИЙ БОДЛОГО……..23

2.1. Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжилт……..23
2.2. Мөнгөний бодлогын хэрэгсэл……...28
2.3. Мөнгөний үзүүлэлтүүдийн байдал……...39
2.4. Банк хоорондын мөнгөний зах ……45

3. ВАЛЮТЫН ХАНШИЙН БОДЛОГО, НӨӨЦИЙН УДИРЛАГА……..46

3.1. Валютын ханшийн бодлого……46
3.2. Гадаад валютын нөөцийн удирдлага……50

4. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ……53

4.1. Банкны салбарын үзүүлэлтүүд……...53
4.2. Банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт……62

5. ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ……64

6. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА……..68

7. МОНГОЛБАНКНААС 2010 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

8. АУДИТОРЫН ТАЙЛАН

9. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД

I. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

1.1 Бодит эдийн засгийн хөгжил

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээгээр манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2009 онд 1.3 хувиар буурсан бол 2010 онд урьдчилсан байдлаар 6.1 хувиар өслөө. Энэхүү өсөлтийн 5.5 нэгжийг бүтээгдэхүүний цэвэр татвар, 1.7 нэгжийг бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 1.1 нэгжийг тээвэр агуулахын үйл ажиллагааны салбар, 1.1 нэгжийг уул уурхай, олборлох салбар тус тус бүрдүүлсэн бол хөдөө аж ахуйн салбар -3.4 нэгжээр, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа -1.2 нэгжээр бууруулсан байна.

Өмнөх онтой харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 54.2 хувиар (ДНБ-ий 12.1 хувь), бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 23.4 хувиар (ДНБ-ий 7.2 хувь), барилгын салбар 15.6 хувиар (ДНБ-ий 1.3 хувь), боловсруулах үйлдвэрлэл 11.3 хувиар (ДНБ-ий 6.5 хувь), тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 9.1 хувиар (ДНБ-ий 8.1 хувь), мэдээлэл холбооны салбар 8.8 хувиар (ДНБ-ий 3.2 хувь) өссөн бол санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 31.5 хувиар (ДНБ-ий 1.9 хувь), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар 16.8 хувиар (ДНБ-ий 15.9 хувь) буурсан байна.

Хүснэгт1. Дотоодын нийт бүтээгдэхүүн (2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)

	2007	2008	2009	2010*
ДНБ	**3639987.7**	**3963960.0**	**3913673.2**	**4153972.8**
өсөлт (%)	***10.2***	***8.9***	***-1.3***	***6.1***
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт	734097.9	768399.4	796318.3	662566.5
өсөлт (%)	*14.4*	*4.7*	*3.6*	*-16.8*
Уул уурхай, олборлолт	683848.5	672649.2	711478.9	756378.0
өсөлт (%)	*1.1*	*-1.6*	*5.8*	*6.3*
Боловсруулах үйлдвэрлэл	250807.8	257538.2	234276.8	260682.6
өсөлт (%)	*27.5*	*2.7*	*-9.0*	*11.3*
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	83531.6	90303.7	96023.7	101461.3
өсөлт (%)	*6.2*	*8.1*	*6.3*	*5.7*
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	15219.4	16539.3	17333.8	18162.9
өсөлт (%)	*6.5*	*8.7*	*4.8*	*4.8*
Барилга	90895.4	78397.1	51716.6	59788.2
өсөлт (%)	*7.2*	*-13.8*	*-34.0*	*15.6*
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	274253.4	315490.3	278185.3	343241.1
өсөлт (%)	*5.5*	*15.0*	*-11.8*	*23.4*
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	356819.6	425540.7	459404.4	501156.3
өсөлт (%)	*25.2*	*19.3*	*8.0*	*9.1*
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	24150.3	25539.8	24669.4	26378.6
өсөлт (%)	*14.7*	*5.8*	*-3.4*	*6.9*
Мэдээлэл холбоо	132439.7	157640.1	169469.7	184303.7
өсөлт (%)	*24.2*	*19.0*	*7.5*	*8.8*

Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	130038.2	169610.9	143092.9	98059.8
өсөлт (%)	*19.5*	*30.4*	*-15.6*	*-31.5*
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	166500.6	180334.4	195502.6	188628.9
өсөлт (%)	*-0.3*	*8.3*	*8.4*	*-3.5*
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	16835.4	27355.3	30391.8	29277.3
өсөлт (%)	*-12.1*	*62.5*	*11.1*	*-3.7*
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	41049.4	54818.8	59911.0	62393.3
өсөлт (%)	*10.4*	*33.5*	*9.3*	*4.1*
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	68845.0	70979.8	75588.6	76298.6
өсөлт (%)	*3.4*	*3.1*	*6.5*	*0.9*
Боловсрол	90357.5	96087.4	100168.8	102390.1
өсөлт (%)	*0.9*	*6.3*	*4.2*	*2.2*
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	44476.2	46581.0	47910.3	48078.0
өсөлт (%)	*9.4*	*4.7*	*2.9*	*0.4*
Урлаг, үзвэр, тоглоом наадам	8660.7	9882.0	9315.0	8968.8
өсөлт (%)	*6.5*	*14.1*	*-5.7*	*-3.7*
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	17631.8	20118.5	18961.2	18268.2
өсөлт (%)	*6.5*	*14.1*	*-5.8*	*-3.7*
Бүтээгдэхүүний цэвэр татвар	409529.3	480154.2	393954.1	607490.7
өсөлт (%)	*6.8*	*17.2*	*-18.0*	*54.2*

Эх үүсвэр: Үндэсний сатистикийн хороо, *Урьдчилсан гүйцэтгэлээр

Инфляци

Тайлант онд инфляци улсын хэмжээнд 13.0 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 14.3 хувьд хүрлээ. Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-д их жин эзэлдэг хүнсний барааны бүлгийн үнэ 21 хувиар, хувцас бөс бараа, гутлынх 12 хувиар, орон сууц, ус, түлш, цахилгааны бүлгийнх 13 хувиар өсч голлох нөлөөг үзүүлэв. Хүнсний барааны үнийн өсөлт нь нийт ХҮИ-ийн өсөлтийн 60 гаруй хувийг бүрдүүлж байгаа нь өнгөрсөн оны зуднаар их хэмжээний мал хорогдсноос мах, сүүн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой юм.

Улсын нэгдсэн төсөв

ҮСХ-ны мэдээгээр тайлант онд урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн нийт дүн 3078.4 тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 3076.3 тэрбум төгрөг болж, нийт тэнцэл 2.2 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Төсвийн урсгал орлого 3035.9 тэрбум төгрөг, урсгал зардал 2271.2 тэрбум төгрөг болж, урсгал тэнцэл 764.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Улсын нэгдсэн төсвийн орлого 55 хувиар өсөхөд татварын нийт орлого өмнөх оныхоос 65 хувиар нэмэгдсэн нь, тэр дундаа зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 2.3 дахин, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 90 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 78 хувиар, онцгой албан татвар 61 хувиар өсч, голлон нөлөөлжээ. Харин татварын бус орлого өмнөх оныхоос 2.9 хувиар өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 32 хувиар нэмэгдэхэд татаас, шилжүүлэг 32 хувиар, цалин, хөлсний зардал 13 хувиар, үйлчилгээний бусад зардал 38 хувиар, хөрөнгийн зардал 23 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Гадаад худалдаа

ҮСХ-ны мэдээгээр манай орны нийт гадаад худалдааны эргэлт 2010 онд өмнөх оноос 53 хувиар өсч 6177.1 сая ам.доллар, нийт экспорт 54 хувиар өсч 2899.2 сая ам.доллар, нийт импорт 53 хувиар өсч 3277.9 сая ам.доллар болжээ. Гадаад худалдааны тэнцэл 378.7 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2009 онтой харьцуулахад 126.4 сая ам.доллар буюу 50 хувиар нэмэгджээ. Нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний экспорт (нийт экспортын 98 хувь) өмнөх онтой харьцуулахад 1091 сая ам.долларaар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэр

ҮСХ-ны мэдээгээр аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл (2005 оны үнээр) 10 хувиар өсч, өмнөх онтой харьцуулахад 13.2 нэгжээр нэмэгдэв. Нүүрс олборлолт 91.8 хувь, газрын тос шатдаг хий олборлолт 16.7 хувь өссөн бол боловсруулах аж үйлдвэрийн салбарт хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 24 хувь, төмрийн үйлдвэрлэл 29.6 хувь, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл 54 хувиар өслөө.

Зураг1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, салбараар



Тайлант онд 4468.2 тэрбум төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулсны 70.6 хувь нь олборлох аж үйлдвэрийн, 21 хувь нь боловсруулах үйлдвэрийн, 8.4 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн борлуулалт байна. Нийт борлуулалтын 68.5 хувийг, олборлох аж үйлдвэрийн борлуулалтын 91.9 хувийг, боловсруулах үйлдвэрийн 17.6 хувийг экспортложээ. Үүнд: газрын тос олборлолтын салбарт 100 хувь, ашигт малтмал олборлолтын 79.2 хувь, металлын хүдэр олборлолтын бүтээгдэхүүний 92.9 хувь, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 64.2 хувь, төмрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 47.1 хувийг тус тус гадаадын зах зээлд борлуулжээ. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 53 хувийг Улаанбаатар хотод, 27 хувийг Орхон аймагт борлуулсан байна.

Хөдөө аж ахуй

Өнгөрсөн оны зуднаар малын тоо 11.3 сая буюу 25.7 хувиар буурсан. Үүний улмаас хөдөө аж ахуйн салбарын өсөлт 16.8 хувиар буурч өмнөх оны өсөлтөөс 20.4 нэгжээр багаслаа.

Зураг2.Малын тоо аймгуудаар, 2010 он



Зураг3. Малын тоо төрлөөр



Тариалсан нийт талбай 315.3 мянган га болж, өмнөх оноос 11.7 хувиар ихэссэн байна. Тайлант онд 355.1 мянган тонн үр тариа, 168 мянган тонн төмс, 82.3 мянган тонн хүнсний ногоо хурааж, 1132.2 мянган тонн өвс хадлан болон 31.3 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2009 оныхоос үр тариа 9.3 хувиар бага, харин төмс 11.1 хувиар, хүнсний ногоо 5.5 хувиар, өвс хадлан 24.3 хувь, гар тэжээл 21.1 хувиар тус тус өсчээ.

Барилга

Урьдчилсан гүйцэтгэлээр барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2010 онд 350.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 25.6 хувиар бага байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 33.5 хувийг инженерийн барилга байгууламж, 28.8 хувийг орон сууцны барилга, 26.6 хувийг орон сууцны бус барилга (үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний, эмнэлэг, сургууль, соёлын г.м.), 11.1 хувийг их

засварын ажил тус бүр эзэлж байна. Мөн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 65 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Тээвэр, холбоо

Тайлант онд тээврийн бүх төрлийн хэрэгслээр 29.4 сая тонн ачаа, давхардсан тоогоор 250.7 сая зорчигч тээвэрлэсэн бөгөөд өмнөх оноос ачаа тээвэрлэлт 18.7 хувь, зорчигч тээвэрлэлт 7.8 хувиар өссөн байна. Тээврийн салбарын нийт орлого 604.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 30 хувиар нэмэгджээ. Авто техникийн улсын үзлэг, тооллогын дүнгээр 2010 онд 284.7 мянган тээврийн хэрэгсэл байгаагаас 153.9 мянган ширхэг буюу 60.4 хувь нь суудлын машин байна. Үүний 59 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Шуудан холбооны нийт орлого 401.6 тэрбум төгрөгт хүрч жилийн хугацаанд 21.6 тэрбум төгрөг буюу 5.7 хувиар өсөв. Үүнээс хүн амаас орсон орлого 315 тэрбум төгрөгт хүрч, нийт орлогын 79 хувийг бүрдүүлжээ.

Хөдөлмөрийн бүтээмж

ҮСХ-ны мэдээгээр тайлант оны эцэст аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 5 хувиар нэмэгдэж 36.5 сая төгрөгт хүрсэн байна. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо нэмэгдсэн өртгийн хэмжээг ажиллагчдын жилийн дундаж тоонд хуваж тодорхойлжээ. Аж үйлдвэрийн салбаруудаас хамгийн өндөр хөдөлмөрийн бүтээмжтэй уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмж 69.1 сая төгрөг бөгөөд энэ дотроо газрын тос, хий олборлох үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 16.7 хувиар нэмэгдэж 299.1 сая төгрөг болсон байна. Мөн боловсруулах аж үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 8.3 хувиар өсч 25.7 сая төгрөгт, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн хөдөлмөрийн бүтээмж 2009 оны жилийн эцсийнхээс 5.5 хувиар нэмэгдэж 15.7 сая төгрөг болсон байна.

Ажил эрхлэлт

Зураг4. Нийт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо



Тайлант онд 46.3 мянган хүн ажилд зуучлуулж орсон нь 2009 онтой харьцуулахад 10.4 хувиар буурсан байна. Ажилд орсон хүмүүсийн 12.3 хувь нь төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагад, 87.7 хувь нь компани, хоршоо, бусад байгууллагад оржээ.

Цалин

Ажиллагсадын 2010 оны сарын дундаж цалин 341.5 мянган төгрөгт хүрч, 2009 оныхоос 41.0 мянган төгрөг буюу 13.6 хувиар нэмэгдсэн болохыг ҮСХ мэдээллээ.

Зураг5. Сарын дундаж цалин 12 сарын дунджаар



Эрэгтэйчүүдийн сарын дундаж цалин 2010 онд 370.4 мянган төгрөг, эмэгтэйчүүдийнх 314.6 мянган төгрөг байв.

Зураг6. Дундаж цалин, салбарын ангиллаар, 2010 он



Шигтгээ1. Дэлхийн эдийн засгийн байдал, Монголын эдийн засагт дахь гадаад нөлөө

Манай орны эдийн засагт уул уухайн салбар голлох үүрэг гүйцэтгэх боллоо. Үүний улмаас гадаад улсууд руу экспортлох уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ, гадаад орноос орж ирэх хөрөнгийн дотогшлох урсгал 2010 онд үлэмж нэмэгдэж шинэ нөөц бололцоо

олгохын зэрэгцээ шинэ хүндрэлүүдийг дагуулж байна. Дэлхийн томоохон улсуудын явуулж байгаа мөнгөний тэлэх бодлого эрэлтийг ихэсгэхийн зэрэгцээ хөрөнгийн урсгалыг хөгжиж буй орнууд руу хандуулсан. Ийнхүү орж ирсэн мөнгө нь төгрөгийн ханшийг чангаруулахын зэрэгцээ, дотоод зах зээлд байгаа мөнгөний хэмжээг нэмэгдүүлжээ.

Зураг7. Нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш зүүн тэнхлэгт, экспорт баруун тэнхлэгт



Эх сурвалж: Монголбанк

Зургаас харахад экспортын хэлбэлзэл ханшийн хэлбэлзэлтэй ойролцоо байгаа ба бодит үйлчилж буй ханш оны эхнээс 30 хувь чангарсан байна. Бодит болон нэрлэсэн үйлчилж буй ханшийн зөрүү нь төлбөр тооцоонд голлон хэрэглэгддэг валютуудыг гүйлгээнд гаргадаг улсуудын инфляцаас манай улсын инфляци хэр өндөр байгааг харуулж байна. Уул уурхайн салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт нь бодит цалинг нэмэгдүүлснээр худалдаалагддаггүй бүтээгдэхүүний үнийг өсгөж, бодит ханш чангарахад нөлөөлжээ.

1.2 Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2010 онд 6.1 хувьд хүрч байж, 2009 оноос 7.7 нэгж хувиар нэмэгдсэн, гадаад худалдааны нийт эргэлт 6177.1 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 53.5 хувиар өссөн зэрэг нь эдийн засаг сэргэн, үйл ажиллагаа нь идэвхжиж байгааг илэрхийлж байна. 2010 онд урсгал данс 931.5 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 1250.2 сая долларын ашигтай, алдаа ба орхигдуулга 318.8 сая ам.долларт байж Монгол Улсын төлбөрийн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр 906.4 сая ам.долларын ашигтай гарлаа.

Урсгал тэнцэл

Тайлант онд урсгал тэнцэл 931.5 сая	*Зураг8. Урсгал дансны гүйцэтгэл /цэвэр/,*

ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ ДНБ-ий 15.3 хувьтай тэнцэхүйц хэмжээнд хүрсэн нь 2009 оноос 2 дахин өсчээ. Энэ нь урсгал тэнцлийн тогтворгүй байдлын эрсдэл улам бүр нэмэгдэж байгааг харуулж байна. Урсгал тэнцлийн алдагдал мөнгөн дүнгээрээ 2009 оноос 2.7 дахин өсөхөд бараа ба үйлчилгээний дансны алдагдал 556.9 сая ам.долларт хүрч 1.7 дахин, цэвэр орлогын дансны алдагдал 560.6 сая ам.долларт хүрч 2.9 дахин өссөн нь нөлөөлөв.

сая ам.доллараар



Эх сурвалж: Монголбанк

Барааны гадаад худалдаа

Барааны худалдааны алдагдал 277.8 сая ам.долларт хүрч, 2009 оноос 47.1 хувиар өссөн бол экспортоос импортын дүнг хасч тооцсон барааны худалдааны алдагдал 9.3 хувиар буурч 428.1 сая ам.долларт хүрчээ. Барааны гадаад худалдааны нийт эргэлт, экспорт, импортын хэмжээ өсөхөд экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ болон дэлхийн зах зээл дэх үнийн өсөлт, уул уурхайн техник, тоног төхөөрөмжийн импорт, нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнийн өсөлтүүдээр тус тус тайлбарлагдаж байна.

Зураг9. Барааны гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллараар



Эх сурвалж: Монголбанк

Тайлант онд чулуун нүүрсний экспортын биет хэмжээ 133.4 хувиар өссөн тул экспортын мөнгөн дүн 186.1 хувиар өслөө. Зэсийн баяжмалын экспорт 53.5 хувиар өсөхөд дэлхийн зах зээл дэх А зэрэглэлийн цэвэр зэсийн үнэ 1.5 дахин өссөн, төмрийн хүдэр ба баяжмалын экспорт 182.7 хувиар өсөхөд биет хэмжээ нь 121.5 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна. Түүнчлэн боловсруулаагүй нефть, цайрын хүдэр ба баяжмал, ямааны самнасан ба угаасан ноолуур, жонш, молибдений хүдэр ба баяжмалын экспортын орлого өссөн бол алтны экспорт 42.2 хувиар буурчээ. Үүнд алтны экспортын биет хэмжээ 53.5 хувиар буурсан нь нөлөөлөв. 2010 онд экспортын орлого 53.8 хувиар өсч 2899.2 сая ам.долларт хүрчээ.

Импорт 53.3 хувиар өсч 3277.9 сая ам.долларт хүрэхэд:

- хүнд машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл,

- тээврийн хэрэгсэл,
- нефтийн импорт харгалзан 95.4, 150.1, 28.4 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлэв.

Эдгээрээс гадна өргөн хэрэглээний бүх төрлийн бараа, бүтээгдэхүүний импорт 2010 онд өсчээ. Нефтийн импорт 678 сая ам.долларт хүрч өссөний 72 хувь нь үнийн өсөлтөөс шалтгаалжээ. Тухайлбал Уралын газрын тосны дундаж үнэ 2010 онд дунджаар 29.4 хувиар өсч 77.9 ам.доллар/баррель-д хүрсэн бол манай улсын импортын нефтийн бүтээгдэхүүний дундаж үнэ 18.6 хувиар өсч 796.8 ам.доллар/тонн болжээ.

Хүснэгт2. Экспорт, сая ам.долларраар

№	Нэр төрөл	2009 Хэмжээ /тн, баррель/	2009 Мөнгөн дүн	2010 Хэмжээ /тн, баррель/	2010 Мөнгөн дүн	Мөнгөн дүнгийн өөрчлөлт
1	Чулуун нүүрс	7 093 497	305,7	16 559 009	874,6	186,1% ↑
2	Зэсийн баяжмал	586 982	501,9	568 664	770,6	53,5% ↑
3	Төмрийн хүдэр ба баяжмал	1 598 123	88,8	3 539 320	250,9	182,7% ↑
4	Мөнгөжөөгүй алт	10 877	308,5	5 060	178,3	-42,2% ↓
5	Боловсруулаагүй нефть	1 938 541	115,6	2 078 682	154,9	34,0% ↑
6	Цайрын хүдэр ба баяжмал	150 737	122,5	119 789	134,1	9,5% ↑
7	Ямааны угаасан ноолуур	3 527	90,9	3 016	104,6	15,0% ↑
8	Ямааны самнасан ноолуур	1 623	68,4	977	68,8	0,7% ↑
9	Жонш, лейцит, нефелинт	314 017	48,2	376 049	63,2	31,0% ↑
10	Молибдений хүдэр ба баяжмал	6 652	50,3	4 769	52,0	3,3% ↑
	Бусад		184,5		247,1	33,9% ↑
	Нийт экспорт		**1 885,4**		**2 899,2**	**53,8% ↑**

Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Хүснэгт3. Импорт, сая ам.долларраар

	Нэр төрөл	Эхний 12 сар 2009	Эхний 12 сар 2010	Өөрчлөлт /хувиар/
1	Нефтийн бүтээгдэхүүн	527,9	678,0	28,4% ↑
2	Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	279,5	546,2	95,4% ↑
3	Тээврийн хэрэгсэл	168,8	422,2	150,1% ↑
4	Хүнсний бүтээгдэхүүн	155,6	168,9	8,6% ↑
6	Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	82,7	114,2	38,1% ↑
7	Эм болон химийн биологийн бүтээгдэхүүн, бордоо	41,1	63,5	54,4% ↑
5	Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	60,4	22,8	-62,2% ↓
8	Төрөл бүрийн даавуу	1,5	1,7	14,7% ↑
9	Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	92,7	124,2	34,0% ↑
	Бусад	727,4	1 136,2	56,2% ↑
	Нийт импорт	**2 137,7**	**3 277,9**	**53,3% ↑**

Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Үйлчилгээний худалдаа

Монгол Улс 2010 онд нийт 490.4 сая ам.долларын үйлчилгээг экспортолж, 769.5 сая ам.долларын үйлчилгээг импортолсноор үйлчилгээний худалдааны данс 279.0 сая ам.долларын алдагдалтай болж 2009 онтой харьцуулахад 94.8 хувиар алдагдал өсчээ.

Үйлчилгээний эргэлтийн 85 гаруй хувийг тээвэр, аялал жуулчлал, бизнесийн бусад үйлчилгээ эзэлж байна. Тайлант онд тээврийн үйлчилгээ 115.3 сая, бусад үйлчилгээ 148.5 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2009 оноос харгалзан 70.3, 47.9 хувиар их юм. 2009 онд 24.9 сая ам.долларын ашигтай байсан аялал жуулчлалын үйлчилгээ 2010 онд 15.2 сая ам.долларын алдагдалтай гарч 161 хувиар муудсан байна. Харилцаа

Зураг10. Үйлчилгээний худалдаа /цэвэр/, сая ам.долларраар



Эх сурвалж: Монголбанк

холбоо, санхүү, барилга, даатгал, патент, лиценз, компьютер, мэдээлэл, бизнес, Засгийн газрын зэрэг үйлчилгээ бүгд алдагдалтай байна.	

Цэвэр орлогын данс

Гадаадын хөрөнгө оруулалттай этгээдүүд харъяат бус хувьцаа эзэмшигчиддээ 345.4 сая ам.долларын ногдол ашгийг хуваарилж, гадны хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн эх үүсвэрт 5.4 сая ам.долларын хүү төлсөн бол Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийнхэн гадаадаас авсан зээлийн эх үүсвэрт 67.0 сая ам.доллар, банкууд эдийн засгийн харьяат бус этгээдээс байршуулсан харилцах, хадгаламжийн эх үүсвэрт 4.21 сая ам.долларыг хүүгийн төлбөрт тус тус зарцуулсан байна.

Монгол Улсад ажиллаж буй гадаадын ажиллагсдад олгосон цалин хөлсний хэмжээ 45.3 сая ам.долларт хүрснээр ажиллагсдын цалин хөлсний данс цэвэр дүнгээр 28.8 сая ам.долларын алдагдалтай болж, алдагдлын хэмжээ нь 2009 оноос 7.4 дахин өсчээ. Хөрөнгө оруулалтын орлогын данс 531.8 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2009 онтой харьцуулахад 2.8 дахин өссөн үзүүлэлт болов. Эдгээр нь цэвэр орлогын данс тайлант онд 560.6 сая ам.долларын алдагдалтай гарч, 2009 оноос 2.9 дахин муудахад нөлөөлөв.	*Зураг11. Орлогын дансны алдагдал, сая ам.доллар*  Эх сурвалж: Монголбанк

Урсгал шилжүүлэг

Цэвэр урсгал шилжүүлэг 185.9 сая ам.долларын ашигтай гарч 2009 оноос 0.2 сая ам.долларaар өсчээ. Үүнд: Монгол иргэдийн эх орон руугаа гуйвуулсан гадаад валют 226.9 сая ам.долларт хүрч 18.5 хувиар, Монголоос гадагш шилжүүлсэн валютын хэмжээ 125.1 сая ам.долларт хүрч 75.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.

Цаашид Монголоос гадагш гуйвуулж буй валютын хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа нь урсгал шилжүүлгийн дансны ашгийг бууруулахаар байна.

Хүснэгт4. Ажиллагсдын гуйвуулга /сая ам.доллар/

	2008	2009	2010	Жилийн өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	68,9	120	101,9	- 18,2	-15,2%
Гаднаас орж ирсэн	218,2	192	226,9	35,4	18,5%
Гадагш шилжүүлсэн	149,4	71,4	125,1	53,7	75,2%

Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл

Тайлант онд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 2148.8 сая ам.долларын ашигтай гарсан нь 2009 онтой харьцуулахад 2.8 дахин өссөн үзүүлэлт юм.

Уг өсөлтөд:

- гадаадын шууд хөрөнгө оруулалт 2009 оноос 2.8 дахин өсч 1573.6 сая ам.долларт хүрсэн,
- 2009 онд 82.1 сая ам.долларын алдагдалтай байсан багцын хөрөнгө оруулалт 878.7 сая ам.долларын ашигтай гарсан,
- санхүүгийн данс 1974.3 сая ам.долларт хүрч 2009 оноос 3.2 дахин нэмэгдсэн,
- хөрөнгийн дансны ашиг 2009 оноос 8.7 хувиар өссөн зэрэг нь голлон нөлөөлөв.

Зураг12. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл, сая ам.доллар

Эх сурвалж: Монголбанк

Бусад хөрөнгө оруулалтын данс 2009 онд 120.6 сая ам.долларын ашигтай байсан бол тайлант онд 478.0 сая ам.долларын алдагдалтай болжээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын 28 хувь нь БНХАУ-аас, 24 хувь нь ОХУ-аас, 14 хувь нь Хонг Конгоос, 9 хувь нь Их Британиас ирсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 66 хувь нь уул уурхай, банк, барилгын салбарт оржээ.

Зураг13. Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт, улс орноор	*Зураг14. Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт, салбараар*



Эх сурвалж: Монголбанк



Эх сурвалж: Монголбанк

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант онд 878.7 сая ам.долларын ашигтай гарсан нь дараах хүчин зүйлсээр шалтгаалсан байна. Үүнд:

- Хөрөнгийн хувьцаа: "Монголиан Майнинг Корпорэйшн" Хонг-Конгийн биржээр дамжуулж, өөрийн хөрөнгийн 20 хувьтай тэнцэх хувьцааг олон улсын хөрөнгийн захад арилжаалснаар нийт 651 сая ам.долларын хөрөнгийг босгосон юм.
- Бонд: Худалдаа хөгжлийн банк нь *"Европын дунд хугацааны үнэт цаасны хөтөлбөр"*-ийн хүрээнд 2007 онд олон улсын санхүүгийн зах зээлд 3 жилийн хугацаатай гаргасан 75 сая ам.долларын бондын үлдэгдэл болох 41.3 сая ам.долларын бондыг тайлант хугацаанд эргүүлэн худалдан авчээ. Мөн уг хөтөлбөрийн хүрээнд 175 сая ам.долларын бондыг дахин гаргаад байна.
- Алтны санхүүжилт болон бусад: Монгол Улсын Засгийн газар алт олборлогчдыг дэмжих зорилгоор Стандарт банкаар дамжуулж 2009 онд олон улсын зах дээр гаргасан 66.2 сая ам.долларын (хямдруулсан үнэ) бондын төлбөрт 75 сая ам.доллар төлсөн. Түүнчлэн Засгийн газраас 30.0 тэрбум төгрөг (22.4 сая ам.доллартай тэнцэх)-ийн үнэлгээ бүхий үнэт цаасыг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалсны 80 хувийг нь буюу 17.9 сая ам.долларын үнэт цаасыг харьяат бус этгээд худалдан авчээ.

Бусад хөрөнгө оруулалт

Монгол Улсын Засгийн газар олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас тайлант онд нийт 65.8 сая ам.долларын урт хугацааны хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авч, 51.4 сая ам.долларын зээлийг буцаан төлснөөр Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 1832.4 сая ам.долларт хүрчээ. Сангийн яамны мэдээллээс үзэхэд гадаад өрийн 78 хувийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон улсаас авсан зээл эзэлж байна. Нийт өрийн 60 орчим хувийг олон улсын санхүүгийн байгууллагаас авсан олон талт зээл, үлдэх 40 гаруй хувийг гадаад орны Засгийн газраас авсан хоёр талт

зээлийн үлдэгдэл тус тус бүрдүүлж байна. Засгийн газрын нийт гадаад өрийн дийлэнх буюу 94 хувь нь гадаад валютаар төлөгдөх юм.

Зураг15. Засгийн газрын гадаад өрийн бүтэц, улс орон, байгууллагаар



Эх сурвалж: Сангийн яам

Зураг16. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл, валютын төрлөөр



Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын Засгийн газар 1990-2009 оны хооронд нийт 2114.5 сая ам.долларын зээл гадаадаас авч ашигласны 52 хувийг дэд бүтцийн салбарт, 41 хувийг бусад салбарт, 7 хувийг нийгмийн салбарт зарцуулжээ. Нийт зээлийн 50 гаруй хувийг зам тээвэр, эрчим хүч, эдийн засгийн бусад салбарт зарцуулсан байна. Тайлант онд аж ахуйн нэгжүүд 236.9 сая ам.долларын урт хугацаат, 118.4 сая ам.долларын богино хугацаат зээлийн эх үүсвэрийг бусад хөрөнгө оруулалт хэлбэрээр гадаад зах зээлээс авч ашиглан, 273.9 сая ам.долларын өрийг эргүүлэн төлжээ.

Хүснэгт5. Гадаад зээлийн ашиглалт, салбараар

Салбараар	сая ам.доллар	эзлэх хувь
Нийгмийн салбар	**141,8**	**7%**
Боловсрол	40	2%
Нийгмийн даатгал, ядуурлыг бууруулахад	65,3	3%
Эрүүл мэнд	36,5	2%
Дэд бүтцийн салбар	**1118,7**	**52%**
Зам тээвэр	429,8	20%
Эрчим хүч	318,7	15%
Уул уурхай	119	6%
Харилцаа холбоо	78	4%
Аж үйлдвэр	173,2	8%
Эдийн засгийн бусад салбар	**883,8**	**41%**
Санхүү эдийн засаг	332,2	15%
НАА орон сууц	83,5	4%
Хөдөө аж ахуй	60,4	3%
ОУВС-гийн зээл	102,3	5%
Бусад	305,4	14%
НИЙТ	**2144,3**	**100%**

Эх сурвалж: Сангийн яам

Гадаад өрийн статистикийг гаргах олон улсын стандартын дагуу Монгол Улсын “Хувийн хэвшлийн нийт гадаад өр” буюу гэрээний дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэй эх үүсвэр (өрийн бичиг, бонд, хөрөнгө оруулагчаас авсан зээл, санхүүжилт зэрэг хамаарна)-ийг нэгтгэн тооцвол 1980.5 сая ам.долларт хүрсэн нь 2009 онтой харьцуулахад 2.6 дахин нэмэгдсэн байна. Эдийн засгийн тэлэлт, түүний эерэг хүлээлт, бизнесийн мөчлөгийн идэвхжилтэй уялдан цаашид хувийн хэвшлийн гадаадаас авах зээлийн хэмжээ өсөх хандлагатай байна.

Зураг17. Хувийн хэвшлийн гадаад өрийн ашиглалт, төлөлт, сая ам.доллараар



Эх сурвалж: Монголбанк

Зураг18. Хувийн хэвшлийн нийт гадаад өрийн үлдэгдэл, сая ам.доллараар



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн төсөөлөл

Монголбанкнаас 2011 оны 2 дугаар сард хийсэн төсөөллөөр 2011 онд төлбөрийн тэнцлийн урсгал данс 1.9 тэрбум ам.долларын алдагдалтай, хөрөнгө санхүүгийн данс 2.9 тэрбум ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 1.0 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна. 2011 онд нийт экспорт 0.9 тэрбум ам.доллараар өсөхөөр байгаа нь 2010 оноос 31 хувиар өсөх юм. Үүнд: чулуун нүүрс, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ, дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ, чулуун нүүрсний хилийн үнийн өсөх төсөөлөл орж байна. Эдийн засаг харьцангуй сэргэх, Оюу толгой, Таван толгой төслүүдийн хөрөнгө оруулалт нэмэгдэхтэй уялдан нийт импортын хэмжээ 2010 оноос 62 хувиар өсч 5.2 тэрбум ам.долларт хүрэх, улмаар барааны гадаад худалдааны алдагдал 1.4 тэрбум ам.долларт хүрч 4.9 дахин нэмэгдэх магадлалтай болов. Импортын өсөлт, уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэхтэй уялдан үйлчилгээний алдагдал 323 сая, цэвэр орлогын дансны алдагдал 365 сая ам.доллар болж нэмэгдэх, урсгал шилжүүлгийн ашиг 161 сая ам.доллар болж буурахаар төсөөлөгдөж байна. Энэ нь урсгал тэнцлийн алдагдлыг 2010 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдүүлэх юм.

Хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 2011 онд өмнөх оноос 33 хувиар өсөхөөр төсөөлөв. Уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжих тул гадаадын шууд хөрөнгө оруулалт 2 дахин өсч 3.2 тэрбум ам.долларт хүрэх тооцоо үүний суурь юм.

Хүснэгт6. Төлбөрийн тэнцлийн 2011 оны төсөөлөл (сая ам.долларaар)

Үзүүлэлт	2010 оны урьдчилсан гүйцэтгэл					2011 оны төсөөлөл				
	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Жилийн	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Жилийн
I. Урсгал Тэнцэл	**-128.8**	**-28.1**	**-214.4**	**-560.1**	**-931.5**	**-250.9**	**-459.2**	**-686.0**	**-498.3**	**-1894.3**
А. Бараа	-65.7	53.3	-148.6	-117.0	**-277.8**	-169.2	-329.5	-539.8	-329.5	**-1367.9**
1. Экспорт Ф.О.Б.	499.0	809.7	717.0	873.5	**2899.2**	623.7	1013.4	1020.8	1130.5	**3788.3**
2. Импорт Ф.О.Б	564.7	756.3	865.5	990.5	**3177.0**	792.8	1342.8	1560.5	1460.0	**5156.2**
Б. Үйлчилгээ /цэвэр/	-61.0	-55.9	-43.0	-119.2	**-279.0**	-72.0	-83.2	-74.6	-92.7	**-322.6**
В. Цэвэр орлого	-36.4	-80.1	-74.6	-369.4	**-560.6**	-57.4	-85.9	-106.4	-114.8	**-364.6**
Г. Урсгал шилжүүлэг /цэвэр/	34.2	54.6	51.7	45.4	**185.9**	47.7	39.4	34.8	38.7	**160.7**
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	**186.2**	**304.3**	**490.2**	**1168.2**	**2148.8**	**303.6**	**777.6**	**1104.8**	**673.9**	**2859.9**
А. Хөрөнгийн данс	28.7	40.9	56.4	48.6	**174.5**	48.6	51.2	49.5	49.8	**199.0**
Б. Санхүүгийн данс	157.5	263.4	433.8	1119.6	**1974.3**	255.0	726.4	1055.3	624.2	**2660.9**
а. Шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	182.1	416.2	454.9	520.4	**1573.6**	465.4	816.2	1181.1	720.7	**3183.5**
б. Багцын хөрөнгө оруулалт /цэвэр/	-80.4	-76.9	7.8	1028.1	**878.7**	23.1	25.5	23.1	29.2	**100.8**
в. Бусад хөрөнгө оруулалт /цэвэр/	55.8	-75.9	-28.9	-428.9	**-478.0**	-233.5	-115.3	-148.9	-125.7	**-623.4**
III. Нийт Төлбөрийн Тэнцэл	**-36.3**	**162.4**	**199.6**	**580.7**	**906.4**	**52.7**	**318.4**	**418.8**	**175.6**	**965.6**
Цэвэр нөөц	**1107.4**	**1229.8**	**1460.1**		**2091.2**	**2143.9**	**2462.3**	**2881.1**		**3056.7**

Эх сурвалж: Монголбанк

1.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр тооцсон Улаанбаатар хотын инфляци 2010 онд 14.3 хувь, улсын хэмжээнд 13.7 хувиар өссөн байна. ХҮИ-ийн сагсыг бүрдүүлж буй бараа, үйлчилгээний бүх бүлгийн үнэ 2010 онд өсчээ. Эдгээрээс хүнсний барааны үнэ 20.6 хувиар, боловсролын үйлчилгээний үнэ 20.4 хувиар, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 16.9 хувиар тус тус нэмэгдсэн нь өндөр өсөлт байлаа. Тухайн бүлгийн сагсанд эзлэх жинг харгалзан үнийн өөрчлөлтийг авч үзвэл сагсанд харьцангуй жин багатай холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний (4.1 хувийн жинтэй) үнэ нэлээд нэмэгдсэн ч индекст үзүүлэх нөлөө нь бага байсан бол сагсанд том жин эзэлдэг хүнс (41.1 хувийн жинтэй), хувцас бөс бараа, гутал (12.4 хувийн жинтэй) болон орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн (13.4 хувийн жинтэй) үнийн өсөлт хүчтэй нөлөөллөө.

ХҮИ-д махны үнийн өөрчлөлт хүчтэй нөлөөлдөг. Тухайлбал, 2010 оны 1-5 дугаар саруудад хонины махны үнэ 14.2-22.9 хувь, үхрийн махных 8.0-22.1 хувиар тус тус нэмэгдсэн нь тухайн саруудын инфляцийг 1.9-4.2 хувиар өсгөж байв. Мөн 2010 оны 6, 7 дугаар сард махны үнэ огцом хямдарахад ХҮИ дагаад огцом буурсан. Хэдийгээр махны үнэ улирлын шинж чанартайгаар өвөл, хаврын үед өсдөг боловч өнгөрсөн өвлийн хувьд махны үнэ өмнөх жилүүдээс харьцангуй илүү нэмэгдсэн.

Инфляцийн хүлээлт, эрэлтийн хүчин зүйлсийг илүү бодитой илэрхийлэх, нийлүүлэлтийн огцом цочролоос ялгаж шинжлэх үүднээс улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү, хүнсний ногоо эсвэл түр зуурын нөлөөлөлд автан хэт их хэлбэлздэг бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч “суурь инфляци”-ийг тооцдог. Суурь инфляци 2010 онд 9.4 хувиар өссөн байна. Үүнд хэрэглээний сагсны бүх бүлгүүдийн үнийн тогтвортой өсөлт жигд байдлаар нөлөөлсөн бөгөөд тэр дундаас хүнсний бүлэг, боловсролын үйчилгээ,

хувцас, бөс бараа, гутлын бүлэг болон орон сууц, ус цахилгаан, түлшний үнийн өсөлт нь харьцангуй хүчтэй нөлөө үзүүлэв.

1.4 Засгийн газрын санхүү

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн 3078.4 тэрбум төгрөг (ДНБ-ий 36.6 хувь), нийт зарлага, цэвэр зээлийн дүн 3076.3 тэрбум төгрөг (ДНБ-ий 36.5 хувь) болж, нийт тэнцэл 2.2 тэрбум төгрөг, урсгал тэнцэл 767.7 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 9.1 хувь) ашигтай дүн гарлаа.

Хүснэгт7. 2010 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

	2009		2010			
	Гүйцэтгэл	Хувийн жин	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хувийн жин	2010/2009 (гүйц), %
Нийт орлого ба тусламж	**1,992,985.8**	**100.0**	**2,695,884.0**	**3,078,418.6**	**100.0**	114.2
Урсгал орлого	**1,965,510.3**	99.1	**2,668,287.6**	**3,035,868.6**	98.6	113.8
Татварын орлого	1,615,251.2	87.6	2,321,384.2	2,673,573.3	88.1	115.2
Орлогын албан татвар	520,006.4	35.2	808,563.8	973,956.2	32.1	120.5
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	257,339.2	10.4	280,842.0	321,659.1	10.6	114.5
Өмчийн татвар	10,979.8	0.4	11,649.6	13,644.8	0.4	117.1
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	508,656.9	25.6	764,293.2	863,467.8	28.4	113.0
Гадаад худалдааны орлого	115,987.5	7.0	165,250.9	193,321.7	6.4	117.0
Бусад татвар	202,281.3	9.1	290,784.7	307,523.7	10.1	105.8
Татварын бус орлого	350,259.1	11.5	346,903.4	362,295.4	11.9	104.4
Хөрөнгийн орлого	**2,958.2**	**0.2**	**5,596.4**	**7,988.5**	**0.3**	**142.7**
Тусламжийн орлого	**24,517.3**	**0.7**	**22,000.0**	**34,561.4**	**1.1**	**157.1**
Нийт зарлага ба цэвэр зээл	**2,321,599.6**	**100.0**	**3,174,160.65**	**3,076,262.8**	**100.0**	96.9
Урсгал зардал	**1,792,065.7**	**77.2**	**2,359,620.1**	**2,271,150.0**	**73.8**	**96.3**
Бараа ба үйлчилгээний зардал	969,549.4	41.8	1,190,244.5	1,193,766.5	52.6	100.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	28,965.6	1.2	54,951.0	41,919.7	3.5	76.3
Татаас ба урсгал шилжүүлэг	793,550.8	34.2	1,114,424.5	1,035,463.7	2470.1	92.9
Хөрөнгийн зардал	**457,923.9**	**19.7**	**654,074.3**	**564,710.8**	**18.4**	**86.3**
Эргэж төлөгдөх цэвэр зээл	**71,610.0**	**3.1**	**160,466.3**	**240,402.0**	**7.8**	**149.8**
Урсгал тэнцэл	**173,444.6**		**308,667.5**	**764,718.7**		**247.7**
Нийт тэнцэл	**(328,613.8)**		**(478,276.6)**	**2,155.8**		

Төсвийн орлого

Нийт орлого, тусламжийн дүн 3078.4 тэрбум төгрөг хүрч төлөвлөсөн хэмжээнээс 14.2 хувь буюу 382.5 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 54.5 хувь буюу 1085.4 төгрөгөөр их байна. Төсвийн нийт орлого, тусламжийн 98.6 хувийг бүрдүүлдэг урсгал орлого өмнөх оны мөн үеэс 54.5 хувь буюу 1070.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нийт орлого, тусламжийн дүн өсөхөд голлон нөлөөлжээ. Урсгал орлогын 88.1 хувийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 65.5 хувь буюу 1058.3 тэрбум төгрөгөөр өссөн нь зарим

бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 126.9 хувь буюу 236.6 тэрбум төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 90.1 хувь буюу 185.2 тэрбум төгрөг, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар 30.6 хувь буюу 34.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ. Мал бүхий иргэний албан татвар 90.1 хувь буюу 1.7 тэрбум төгрөгөөр багассан байна.

Зураг19. Нийт орлого ба тусламж

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 66.7 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 251.5 тэрбум төгрөг буюу 77.2 хувь, онцгой албан татварын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 31.1 хувь) 101.8 тэрбум төгрөг буюу 61.0 хувь, тусгай зориулалтын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 2.1 хувь) 9.8 хувь буюу 1.6 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Тайлант онд гадаад худалдааны орлого 66.7 хувь буюу 77.3 тэрбум төгрөгөөр өсч 193.3 тэрбум төгрөгт хүрсэн нь импортын барааны гаалийн албан татвар 81.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Онцгой албан татварын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 176.5 хувь буюу 59.1 тэрбум төгрөг, дотоодын архины онцгой албан татвар 22.1 хувь буюу 12.3 тэрбум төгрөгөөр өссөн нь онцгой албан татварын өсөлтөд голлон нөлөөлжээ. Бусад татварын орлого 52.0 хувь буюу 105.2 тэрбум төгрөгөөр өсч 307.5 тэрбум төгрөгт хүрсэн нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 60.8 тэрбум төгрөг, газрын төлбөр 3.4 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Төсвийн зарлага

Төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн дүн 3076.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 32.5 хувь буюу 754.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төлөвлөсөн хэмжээнээс 3.1 хувь буюу 97.9 тэрбум төгрөгөөр бага байна.

Зураг20. Нийт зардал, цэвэр зээл

Тайлант онд урсгал зардал өмнөх оны мөн үеэс 26.7 хувь буюу 479.1 тэрбум төгрөгөөр өсч 2271.2 тэрбум төгрөгт, хөрөнгийн зардал 23.3 хувь буюу 106.8 тэрбум төгрөгөөр өсч 564.7 тэрбум төгрөгт, эргэж төлөгдөх цэвэр зээл 3.4 дахин буюу 168.8 тэрбум төгрөгөөр өсч 240.4 тэрбум төгрөгт тус тус хүрчээ. Урсгал зардлыг бүрэлдэхүүн тус бүрээр нь авч үзвэл, бараа үйлчилгээний зардал (урсгал зардлын 52.6 хувь) өмнөх оны мөн үеэс 23.1 хувь буюу 224.2 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр (урсгал зардлын 3.5 хувь) 44.7 хувь буюу 12.9 тэрбум төгрөг, татаас ба шилжүүлэг (урсгал зардлын 44.6 хувь) 30.5 хувь буюу 241.9 тэрбум төгрөөр тус тус өсчээ.

1.5 Хөрөнгийн захын хөгжил

Монголын Хөрөнгийн Бирж 2010 онд үнэт цаасны 253 удаагийн арилжаа явуулж 136 компанийн 64.5 сая ширхэг хувьцаа 62.9 тэрбум төгрөгөөр, 3 мянган ширхэг Засгийн газрын бонд 30 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 92.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ. Хувьцааны арилжааны хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 39.7 тэрбум төгрөг буюу 171.7 хувиар нэмэгджээ. Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оноос 753.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1373.9 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 16.3 хувь байна. Таван толгой, Багануур, Шивээ овоо, АПУ, МЦХ, Шарын гол, Говь зэрэг нь зах зээлийн үнэлгээ өндөр компаниудад орж байна. Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс 2010 онд хамгийн ихдээ 15039.97 нэгж болтлоо өсч, зах зээлийн үнэлгээ түүхэндээ анх удаа нэг их наяд 373.9 тэрбум төгрөгт хүрч өсчээ.

Хүснэгт8. Арилжааны гүйлгээ */тэрбум төгрөг/*

	Арилжааны үнийн дүн	Өөрчлөлт

	2009	2010	Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	-	30.0	30.0	100
Хувьцаа	23.2	62.9	39.7	171.1

ТОП-20 үнийн индексийн үзүүлэлт оны эцэст 14759.81 болж, өмнөх оноос 2.4 дахин нэмэгдсэн байна. ТОП-20 индекс Шарын гол, Могойн гол, Шивээ овоо, Таван толгой, АПУ, Багануур, Талх чихэр, Нако Түлш, Хөх Ган, Мах импекс зэрэг ХК-иудын үнэт цаасны үнэ өссөн тул нэмэгдлээ. ТОП-20 үнийн индескийн 2010 оны дундаж 10582.8 байв.

Зураг21. ТОП 20 индекс, 2010 онд



Эх үүсвэр: Монголын хөрөнгийн биржс

Хувьцааны арилжааны өдрийн дундаж нь хувьцааны тоо ширхгээр 255 мянга, үнийн дүнгээр 248.5 сая төгрөг байв.

Хүснэгт9. Идэвхитэй арилжигдсан үнэт цаас (тоо ширхэгээр)

Д/д	Үнэт цаасны компани	Тоо ширхэг /сая ширхэг/
1	Хөх ган	19.9
2	Женко тур бюро	8.7
3	Гермес центр	7.9
4	Нако түлш	4.6
5	Багануур	3.3
6	Монголиан Девелопмент ресорс	3.0
7	Хай би ойл	2.7
8	АПУ	2.2
9	Ремикон	2.0
10	Шарын гол	1.9

Хүснэгт10. Идэвхитэй арилжигдсан үнэт цаас (үнийн дүнгээр)

Д/д	Үнэт цаасны компани	Үнийн дүн /тэрбум төгрөг/
1	Багануур	21.1
2	Шарын гол	12.4
3	Говь	4.4
4	АПУ	3.6
5	Монголиан Девелопмент ресорс	3.4
6	Хөх ган	3.0
7	Таван толгой	2.6
8	БиДиСек	2.3
9	Шивээ овоо	1.9
10	Улаанбаатар ЗБ	1.5

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржс

II. МӨНГӨНИЙ БОДЛОГО

2.1 Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжилт

Үндсэн зорилтын хүрээнд. Тайлант онд Монголбанк өөрийн үндсэн зорилт болох инфляцийг зорилтот түвшинд байлгах, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бодлогоо чиглүүлэн ажилласан. Ялангуяа төсвийн тэлэх бодлого болон нийлүүлэлтийн талын хүчин зүйлсээс шалтгаалан инфляци тайлант оны эхнээс огцом эрчимжиж эхэлсэн тул Монголбанк мөнгөний бодлогын төлвийг[1] чангаруулж ажиллав.

Зураг22. Жилийн инфляцийн задаргаа, гол хүчин зүйлсээр

[1] Мөнгөний бодлогын төлөв гэдэгт өнгөрсөн хугацаанд мөнгөний хатуу эсвэл зөөлөн бодлого хэрэгжсэн эсэхийг хэмждэг үзүүлэлт юм. Мөнгөний бодлого нь богино хугацаанд валютын ханш болон хүүгийн түвшинд нөлөөлдөг гэж үзэн дээрх 2 хувьсагчаар мөнгөний бодлогын төлвийг хэмждэг.



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Инфляци жилийн эхний хагас жилд тийнхүү хурдтай өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн. *Нэгдүгээрт,* зудын улмаас нийт малын 13.0 хувь хорогдсон үед махны нөөцийг өмнөх жилүүдээс 30 гаруй хувиар бага бэлтгэсэн явдал махны үнэ өмнөх зудтай жилүүдээс ч давж өсөх шалтаг болов. *Хоёрдугаарт,* Хүний хөгжил сангаас эхний ээлжинд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бага насны хүүхдүүдэд 70.0 мянган төгрөгийг бэлнээр олгосон нь инфляцийн өсөлтийг өдөөсөн өөр нэгэн хүчин зүйл болсон. Энэ арга хэмжээ цагаан сартай давхцан иргэдийн хэрэглээг өсгөн нийлүүлэлтийн дутагдалтай байсан орчинд үнийн өсөлтийг улам хурдасгаж үнэ өсөх хүлээлт бий болгосон. *Гуравдугаарт,* төрийн зохицуулалттай 5 төрлийн бараа, үйлчилгээний үнэ 10-37.5 хувиар нэмэгдсэн нь инфляцийн 10 гаруй хувийг тус тус бий болгосон. Ийнхүү инфляци хүнс болон төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ зэрэг нийлүүлэлтийн талын хүчин зүйлсийн үнийн өсөлтөөр голчлон бий болсоны зэрэгцээ иргэдэд олгосон бэлэн мөнгөнөөс үүдэлтэй эрэлтийн талын хүчин зүйлсийн нөлөөгөөр эрчимжсэн. Ийм нөхцөл байдалд Монголбанкнаас дараах арга хэмжээг авлаа. Үүнд:

1. 2010 оны 4 дүгээр сард бодлогын хүүний нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ТБҮЦ-ны арилжаанд хүүний интервалтай арилжааны хэлбэрийг нэвтрүүлэн мөнгөний бодлогыг илүү үр ашигтай хэрэглэх боломжийг нэмэгдүүлсэн.

2. Монголбанк 2010 оны 5 дугаар сард инфляцийн хүлээлтийг бууруулах зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 11 хувьд хүргэсэн. Энэ арга хэмжээ нь

нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалсан инфляцийг хүлээлтээр өдөөгдөхөөс урьдчилан сэргийлсэн алхам байсан юм.

3. Нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор Монголбанк УИХ, Засгийн газарт хандаж инфляцийн шалтгааныг тайлбарлан, түүний эсрэг арга хэмжээ авах саналаа холбогдох танилцуулга, тооцооллын хамт хүргүүлсэн. Үүний үр дүнд Засгийн газраас хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсэг байгуулан хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, зарим арга хэмжээ авсны үр дүнд 6 дугаар сараас махны үнэ буурч эхэлсэн.

Оны сүүлийн хагас жилд 12 дугаар сарыг эс тооцвол инфляцийн түвшин харьцангуй тогтвортой байлаа. Харин 12 дугаар сард махны үнэ эргэн өссөн нь зүүн аймгуудад малын шүлхий өвчин гарснаас нийслэлд орж ирэх махны хэмжээ буурсан, махны экспортын хэмжээ нэмэгдсэн зэрэг шалтгаантай байв.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2010 оны эцэст ХҮИ-ээр тооцсон инфляци улсын хэмжээнд жилийн 13.0 хувь, Улаанбаатар хотод 14.3 хувьд хүрч өмнөх оноос харгалзан 8.8 болон 12.4 нэгж хувиар өслөө. Үнийн өсөлтийн 59.7 хувийг хүнсний барааны үнийн өсөлт бий болгов. Хувцас, бөс барааны үнийн өсөлт инфляцийн 10.6 хувийг; орон сууц, ус цахилгааны үнэ өссөн нь инфляцийн 11.9; харилцаа холбооны үнэ өссөн нь жилийн инфляцийн 4.8 хувийг тус тус бий болгожээ. Үүнээс махны үнийн өсөлт дангаараа инфляцийн 5.9 нэгж хувь буюу 41.3 хувийг бүрдүүлсэн байна.

Зураг23. Жилийн инфляцийн задаргаа



Зураг24. Инфляцийн задаргаа[2]



Эх сурвалж: ҮСХ

Эдийн засгийн өсөлт, зээлийн тасалдал. 2010 онд эдийн засгийн өсөлтийг сэргээх, зээлийн тасалдлыг арилгах зорилгоор эрэлт нэмэгдэж, бизнесийн үйл ажиллагаа идэвхждэг 2

[2]*Оны эхнээс тооцсон инфляци.*

дугаар улиралд банкуудын илүүдэл нөөц, нөөц мөнгөний өсөлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэв.

Зураг25. ДНБ ба зээлийн өөрчлөлт



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Монголбанкнаас барилгын салбарт зээл олгосон банкуудыг дэмжих, нөгөө талаас төрийн албан хаагчдад олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газартай харилцан тохиролцож санхүүжилт олгов. 2010 оны 7 дугаар сарын байдлаар гэрээний дагуу нийт 30.0 тэрбум төгрөгийн 7.8 хувийн хөвөгч хүүтэй Засгийн газрын үнэт цаасыг худалдаж аваад байна. Үүгээр 1409 төрийн албан хаагчдад 51.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэснээс 926 иргэнтэй зээлийн гэрээ байгуулж, орон сууцны санхүүжилт олгосон байна. Зээл авч буй төрийн албан хаагчдын 915 нь банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцнаас худалдан авах сонголтоо хийжээ. Мөн тайлант онд хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үр дүнд ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсад хэрэгжүүлэх “Санхүүгийн салбарыг хөхүүлэн дэмжих-Ипотекийн барьцаат зээлийн системийг дэмжих” төслийн хүрээнд 4.8 сая еврогийн хөнгөлөлттэй зээл, 0.5 сая еврогийн буцалтгүй тусламжийг Монголбанкаар дамжуулан МИК-д олгохоор тохиролцон Германы Сэргээн Босголт Хөгжлийн банк, Монгол Улсын Засгийн газар зээлийн гэрээнд гарын үсэг зурав.

Үндэсний статистикийн хорооны урьдчилсан мэдээгээр тайлант оны эдийн засгийн өсөлт 6.1 хувь гарлаа. 2010 онд М2 мөнгө 4.6 их наяд төгрөгт хүрч, 62.5 хувиар өссөн нь гадаад цэвэр актив 80 хувиар, зээлийн өрийн үлдэгдэл 23 хувиар тус тус өссөнөөр тайлбарлагдаж байна. Зээлийн өрийн үлдэгдэл тайлант онд 3.2 их наяд төгрөгт хүрч өссөн нь зээлийн тасалдал бүрэн арилсныг илтгэж байна.

Зээлийн хүү. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлд заасан ажлын хүрээнд зээлийн хүүг бууруулах эдийн засгийн болон хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээний талаар судалж, холбогдох танилцуулга, төлөвлөөг боловсруулан 2010 оны 11 дүгээр сард Засгийн газар, олон нийт, банк, санхүүгийн байгууллагын төлөөллүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. Тайлант онд банкны зээл болон хадгаламжийн зарласан хүү тогтмол буурав. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж жилийн хүү 2010 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 10.7 хувь болж өмнөх оноос 2.2 нэгж хувиар, зээлийн жигнэсэн дундаж хүү 17.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар тус тус буураад байна. Зээлийн хүүг бууруулахад банкны салбарын чанаргүй зээл нэлээд саад тотгор учруулж байгаа бөгөөд үүнийг банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэх талаар Монголбанкнаас иж бүрэн төлөвлөгөөг боловсруулсан. Оны эхэнд чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 17.4 хувь байсан бол 12 дугаар сарын эцсийн байдлаар 11.5 хувь болж 5.7 нэгж хувиар буурлаа.

Зураг26. Зээлийн зарласан хүү



Эх үүсвэр: Монголбанк

Олон нийттэй харьцах харьцаа. Монголбанк сар бүр Хэвлэлийн хурлыг товыг нь урьдчилан зарлан хуралдуулж, Захирлуудын Зөвлөлийн хурлаас гарсан бодлогын шийдвэр, түүний шалтгааныг олон нийт, санхүүгийн захад тогтмол давтамжтайгаар тайлбарлан хүргэх тогтолцоог шинээр бүрдүүллээ. Энэ ажлыг 2010 оны 6 дугаар сараас эхлүүлсэн бөгөөд ээлжит болон ээлжит бус нийт 9 Хэвлэлийн бага хурлыг зохион байгуулсан байна. Ингэснээр мөнгөний бодлогын нөлөөлөх сувгуудыг сайжруулах, мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх, төв банкнаас явуулж буй бодлогыг олон нийтэд таниулж, сурталчилахад чухал ач холбогдолтой юм.

2.2 Мөнгөний бодлогын хэрэгсэл

Нөөц мөнгө

Нөөц мөнгө 2010 онд 29 хувиар өсч 945.5 тэрбум төгрөг боллоо.

Зураг27. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсгүүд



Зураг28. Нөөц мөнгөний бүтцийн өөрчлөлт



Зураг29. Нөөц мөнгө ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлт /пассив тал/



Төв банк 2010 оны 6 дугаар сар хүртэл зээлийн тасалдлыг арилгах, ханш чангарах хурдыг сааруулах зорилгоор банк хоорондын илүүдэл нөөцийг нэмэгдүүлэх, ТБҮЦ-ны хүү болон банк хоорондын захын хүүг бууруулах бодлого хэрэгжүүлсэн. Харин 2010 оны 6 дугаар сараас төсвийн бодлогын тэлэлт, хувийн секторын идэвхжил, инфляцийн дарамт ихэссэн зэрэгтэй холбоотойгоор бодлогын хүүний нөлөөлөх, дохио өгөх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор банк хоорондын захын илүүдэл нөөцийг бууруулж, төсвийн бодлого болон валютын захын интервенцээр нийлүүлэгдсэн төгрөгийн нөөцийг эргүүлэн татах бодлого хэрэгжүүллээ. Тухайлбал, 2010 оны 5 дугаар сарын эхний хагас хүртэлх хугацааны өдрийн дундаж илүүдэл нөөц 85.6 тэрбум төгрөг байсан бол уг хугацаанаас 2010 оны эцэс хүртэлх хугацааны өдрийн дундаж илүүдэл нөөцийн хэмжээ 42.3 тэрбум төгрөг болж буурсан.

Нөөц мөнгөний өсөлтийг эх үүсвэр талаас авч үзвэл Төв банк дахь харилцах, хадгаламж оны эхнээс 65.9 тэрбум төгрөгөөр буюу 18.2 тэрбум төгрөгөөр, банкнаас гадуурх мөнгө 103.2 тэрбум төгрөгөөр буюу 36.2 хувиар, банкуудын касс 43.3 тэрбум төгрөгөөр буюу 49.9 хувиар тус тус нэмэгдлээ. 2010 оны банкнаас гадуурх мөнгө болон Төв банк дахь харилцах, хадгаламжийн өсөлт нөөц мөнгөний өсөлтийн 48.6 хувь болон 3 хувийг бий болгожээ. Тайлант онд Төв банк дахь банкуудын харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь буурч, банкнаас гадуурх мөнгө, банкуудын кассын эзлэх хувь өссөн. Төв банк дахь банкуудын харилцахын нөөц мөнгөнд эзлэх хувь 45 хувь болж, өнгөрсөн оноос 4 нэгж хувиар буурсан байна. Харин банкнаас гадуурх мөнгө болон банкуудын кассын нөөц мөнгөнд эзлэх хувь тус бүр харгалзан 41 хувь болон 39 хувь болж, тус бүр 2 нэгж хувиар нэмэгдсэн.

Нөөц мөнгөний актив талын бүтцийг авч үзвэл Төв банкны гадаад цэвэр актив тайлант онд 990.3 тэрбум төгрөгөөр буюу 64.4 хувиар өссөн нь нөөц мөнгөний өсөлтөд хүчтэй нөлөөллөө. Төв банкны гадаад валютын цэвэр албан нөөц 2010 онд 946 сая ам.доллараар буюу 82.6 хувиар өссөн нь Төв банкны гадаад цэвэр активын өсөлтийг бий болгосон юм.

Зураг30. Нөөц мөнгө ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлт /актив тал/



Тайлант онд Төв банкны дотоод цэвэр актив /ДЦА/-ын хэмжээ 777.9 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин буурсан нь ТБҮЦ-ны өсөлттэй холбоотой. Уул уурхайн салбарын томоохон төслүүд ашиглалтанд орж, хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэн нь банкны салбарын мөнгөн хөрөнгийн нөөцийг ихээхэн нэмэгдүүлж, нэрлэсэн ханшийн огцом чангарах дарамтыг бий болгож байсан нь илүүдэл нөөц болон нөөц мөнгөний удирдлагад нэлээд хүндрэлийг бий болгож байлаа. Хөрөнгийн дотогшлох урсгалыг зохицуулах зорилгоор Төв банк үнэт цаасныхаа хэмжээг 708.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн юм. Банкууд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орсон үед Төв банкнаас банкуудад олгосон барьцаат зээл болон дахин санхүүжилтийн зээл 67.1 тэрбум төгрөгөөр эргэн төлөгдсөн нь ДЦА-ын буурахад нөлөөлсөн. Мөн ЗГЦЗ болон бусад цэвэр актив 226.2 тэрбум төгрөгөөр болон 223.9 тэрбум төгрөгөөр тус тус буурлаа.

Зураг31. Төвбанкны дотоод цэвэр активын бүтэц



Хүснэгт11. Банкны системийн нөөцийн өөрчлөлт /хүчин зүйлээр/

	2009.12.31-2010.12.31		
	Нийлүүлсэн (Н)	**Татсан (Т)**	**Цэвэр дүн (Н-Т)**
Төв банкны бодлогын хэрэгсэл			
Байнгын санхүүжилт	1,333.5	1,341.3	-7.7
Байнгын бус санхүүжилт	4.0	63.9	-59.9
ТБҮЦ		708.5	-708.5
Дүн (a)	**1,337.5**	**2,113.6**	**-776.1**
Төв банкнаас үл хамаарах хүчин зүйлс			
Гадаад цэвэр активын өөрчлөлтөөр	1,163.3		1,163.3
ЗГЦЗ-ийн өөрчлөлтөөр		229.1	-229.1
Бусад дотоод цэвэр активын өөрчлөлтөөр	55.5		55.5
Гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлтөөр		147.9	-147.9
Дүн (b)	**1,218.8**	**376.9**	**841.9**
Банкуудын нөөц			
ЗБН (c)			59.2
Төгрөгийн			*46.3*
Гадаад валютын			*12.8*
Илүүдэл нөөц (d)			6.7
Төгрөгийн			*-123.7*
Гадаад валютын			*130.4*
Дүн (a)+(b) буюу (c)+(d)			**65.8**

Банкны салбарын нөөцийн өөрчлөлтийн хүснэгтээс харвал тайлант онд Төв банкны бодлогын хэрэгслээс бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр банк хоорондын захад 841.9 тэрбум төгрөгийн нөөц нийлүүлэгдсэн бөгөөд Төв банк бодлогын хэрэгслүүдээрээ дамжуулан

нийт нийлүүлэгдсэн нөөцийн 92 хувь болох 776.1 тэрбум төгрөгийг эргүүлэн татсан. Нөөцийн нийлүүлэлтийн бүтцийг авч үзвэл Төв банкны ГЦА-ын өсөлтөөр 1163.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Олон улсын валютын сан, Монгол Улсын Засгийн газар, Төв банк хамтран хямралын эсрэг Стэнд-бай хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, Монгол Улсын нэр гадаад зах зээл дээр өссөн, уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт эхэлснээр хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэн нь Төв банкны гадаад цэвэр актив, гадаад валютын цэвэр албан нөөц их хэмжээгээр өсөхөд нөлөөлжээ. Харин Засгийн газрын цэвэр зээлийн бууралтаар 229.1 тэрбум төгрөг, гүйлгээнд байгаа мөнгөний өсөлтөөр 147.9 тэрбум төгрөгийн нөөц банк хоорондын захаас тус тус татагдсан.

Манай улсын эдийн засгийн улирлын шинж чанартай хэлбэлзлүүд нь нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрчилдөг. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан нөөц мөнгөний улирлын хэлбэлзлийн өсөх хандлага тайлант онд давтагдсан. Бэлэн мөнгөний эрэлтийг тодорхойлдог банкнаас гадуурх мөнгөний улирлын хэлбэлзэл сүүлийн жилүүдийн хандлагыг даган буурсан байна. Банкнаас гадуурх мөнгө 2010 оны 3 болон 4 дүгээр сард огцом өссөн нь “Хүний хөгжлийн сан”-гаас иргэдэд 70.0 төгрөгийн тэтгэмж олгосонтой холбоотой.

Зураг32. Нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн улирлын хэлбэлзлийн хандлага


Улирлын хэлбэлзлийн индекс /нөөц мөнгө/
1.13
1.10
1.07
1.04
1.01
0.98
0.95
0.92
0.89
2005M01
2005M04
2005M07
2005M10
2006M01
2006M04
2006M07
2006M10
2007M01
2007M04
2007M07
2007M10
2008M01
2008M04
2008M07
2008M10
2009M01
2009M04
2009M07
2009M10


Банкнаас гадуур хмөнгөний бодит ба засварлагдсан утга
Тэрбум ₮
450
400
350
300
250
200
150
100
Бодит утга
Улирлын зохицуулалт хийсэн утга
2005M01
2005M04
2005M07
2005M10
2006M01
2006M04
2006M07
2006M10
2007M01
2007M04
2007M07
2007M10
2008M01
2008M04
2008M07
2008M10
2009M01
2009M04
2009M07
2009M10
2010M01
2010M04
2010M07
2010M10



Төвбанкны үнэт цаас

Монгол Улс ОУВС хамтран 2009-2010 онд Стэнд-Бай хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд Төв банкны үйл ажиллагааны болон завсрын зорилтод мөнгөний хэмжээ (үнэ бус) хэрэглэж байлаа. Хөтөлбөрийн хүрээнд нөөц мөнгөний зорилтот түвшинтэй уялдуулан ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 7 хоногтой ТБҮЦ-ны арилжааг тодорхой интервальд хүүгээр өрсөлдөх хэлбэрээр зохион байгуулав. 2010 онд Монголбанк 7 хоногтой ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй, хэмжээг хязгаарлан зарлах, тодорхой интервальд хүүгээр өрсөлдөх гэсэн хоёр төрлөөр явуулав. 7 хоногтой ТБҮЦ-ны арилжааг тайлант оны эхний хагаст тогтмол хүүтэй, хэмжээг хязгаарлан арилжаалсан бол хоёрдугаар хагасаас эхлэн арилжааны хэмжээнд дээд, доод хязгаар тавьж, хүүний тодорхой интервальд өрсөлдөх зарчмаар арилжаалав. Хүүний интервалийг Төв банкны бодлогын хүү дээр +/-(2) нэгж хувиар тогтоож, арилжаа бүрийн жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүний түвшинд байлгахыг зорьж үнэт цаас худалдан авах саналыг зарласан интервалийн хэмжээтэй уялдуулан хуваарилалт хийв. 12 долоо хоногтой ТБҮЦ-ыг хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар арилжааллаа.

Тайлант онд Монголбанк нийт 78 удаа ТБҮЦ-ны арилжаа зарлаж, өссөн дүнгээр 21034.2 тэрбум төгрөгийн үнэт цаасыг борлуулсан байна. Тайлант оны эцсийн байдлаар ТБҮЦ-ны үлдэгдэл 1106.5 тэрбум төгрөг байв. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.8 дахин өссөн үзүүлэлт юм. Манай улсын уул, уурхайн салбарын үйл ажиллагаа идэвхжсэнээс хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэн, Төв банкны валютын захад оролцох оролцоо нэмэгдсэн учир ингэж илүүдэл нөөц өссөн. Монголбанк банк хоорондын захын тогтвортой байдлыг хадгалах үүднээс валютын дуудлага худалдаагаар нийлүүлсэн төгрөгийг буцаан татах зорилгоор ТБҮЦ-ны хэмжээг нэмэгдүүлж байв. Монголбанк оны

туршид өдөрт дунджаар 621.5 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкуудад байршуулж байсан нь 2009 оныхоос 2.8 дахин өссөн үзүүлэлт юм.

Тайлант онд 12 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг 26 удаа зохион байгуулав. 2010 оны эцсийн байдлаар хугацаа нь дуусаагүй энэ төрлийн үнэт цаасны үлдэгдэл 326 тэрбум төгрөг, тэдгээрийн жигнэсэн дундаж хүү нь 10.22 хувь байна. 2010 оны өвлийн зуднаас болж махны нийлүүлэлт багасч улмаар үнэ нь өссөн, Хүний хөгжлийн сангаас иргэн бүрт 70 мянган төгрөгийг оны эхний хагаст олгож эхэлсэн, 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмэх шийдвэр гарснаар инфляцийн хүлээлт нэмэгдэн оны эхний хагаст инфляцийн дарамт үүсч эхэлсэн тул Монголбанк тайлант оны 5 дугаар сард бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөх шийдвэр гаргаж мөнгөний бодлогыг хатууруулсан.

ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 10.67 хувь байгаа нь 2009 оны эцсээс 0.15 нэгж хувиар доогуур байна. Тайлант онд Монголбанк ТБҮЦ-ны хүүний зардалд 65.7 тэрбум төгрөг зарцуулав. Энэ нь өмнөх оныхоос 38.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

Заавал байлгах нөөцийн шаардлага

Монголбанкнаас банкуудад тогтоодог заавал байлгах нөөцийн хувь хэмжээ нь мөнгөний нийлүүлэлтийг хянах, банкны байгууллагын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг зохицуулах гэсэн хосолмол үүрэгтэй төв банкны бодлогын хэрэгсэл юм. Тайлант хугацаанд нийт 26 удаа заавал байлгах нөөцийн хэмжээг төгрөгөөр болон валютаар банк тус бүрээр тогтоож, түүний хангалтыг тооцож холбогдох арга хэмжээг авч ажилласан. Нөөцөө хангаагүй банк 2010 онд цөөхөн байсан бөгөөд оны эцэст салбарын хэмжээгээр нийт 270.4 тэрбум төгрөгийн нөөцийн илүүдэлтэй байв (банкуудын худалдан авсан ТБҮЦ-ыг оруулж тооцсон дүн болно). Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 98.3 тэрбум төгрөг буюу 57.1 хувиар өссөн дүн болно.

Зураг33. Банкуудын төгрөгийн илүүдэл нөөц ба ЗБН /2010 он/



Зураг34. Банкуудын валютын илүүдэл нөөц ба ЗБН /2010 он/



Банкинд олгосон санхүүжилт

Монголбанк Төв банкны тухай хуулийн дагуу эцсийн зээлдүүлэгчийн хувьд банкны богино хугацааны хөрвөх чадварыг хангах зорилгоор банкинд шаардлагатай санхүүжилтийг олгож ирлээ. Төв банкны санхүүжилтийн хэрэгсэлд өдрийн зээл, овернайт зээл, репо санхүүжилт, барьцаат зээл зэрэг санхүүжилтийн төрлүүд багтаж байна. Эдгээр нь өөр өөрийн зорилго, онцлогтой бөгөөд тухайлбал, өдрийн зээлийн хэрэгсэл нь банкны төлбөр тооцоог саадгүй явуулахад чиглэгдэх бол овернайт зээлийн хэрэгсэл нь тухайн банкны заавал байлгах нөөцийн шаардлагыг хангахад хэрэглэгддэг. Харин репо санхүүжилтээр банк илүү урт хугацаатай буюу 90 хүртэл хоногийн хугацаатай эх үүсвэрээ удирдахад хэрэглэдэг юм.

Өдрийн зээл

Монголбанк 2009 онд банк хоорондын төлбөр тооцоонд гардаг олон төрлийн эрсдэлийг багасгах, төлбөр тооцоог шуурхай хийж гүйцэтгэх зорилгоор бодит цагийн төлбөрийн системийг нэвтрүүлсэн. Төлбөр тооцооны бодит цагийн систем хэрэглэх болсонтой холбоотойгоор төлбөрийн системд оролцогч банкуудын хувьд хөрөнгийн удирдлагыг сайжруулах, үр ашигтай болгох, харилцагчийн төлбөр тооцоог саадгүй явуулах хариуцлага улам бүр нэмэгдлээ. Монголбанкны өдрийн зээлийн хэрэгсэл нь банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилготой юм. Тайлант онд Монголбанк нийт 316.9 тэрбум төгрөгийн өдрийн репо хэлцэл хийв. Өдрийн репо хэлцэл хийх активын төрөлд зөвхөн ТБҮЦ багтаж байна. Монголбанк тайлант онд хүүтэй, барьцаагүй өдрийн зээл олгоогүй.

Репо санхүүжилт

Монголбанк банкны хүсэлтээр олгох репо санхүүжилт, репо арилжаагаар олгох репо санхүүжилт гэсэн хоёр төрлөөр банктай репо хэлцэл хийдэг. Банкны хүсэлтээр олгох репо санхүүжилтийн хүү нь Төв банкны бодлогын хүү дээр нэмэх 4 нэгж хувь байгаа бөгөөд тайлант онд бодлогын хүү 1 нэгж хувиар өссөнөөс шалтгаалж репо санхүүжилтийн хүү 15 хувь болсон байна. Харин репо арилжаагаар олгох санхүүжилтийн хүү арилжааны үр дүн болдог юм. 2010 онд Монголбанк өссөн дүнгээр 1,015.1 тэрбум төгрөгийн репо санхүүжилт банкны хүсэлтээр олгосон бөгөөд жигнэсэн дундаж хүү нь 14.25 хувь байв.

Барьцаат зээл

Монголбанк Төв банкны тухай хуульд нийцүүлэн 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан “Банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын дагуу эцсийн зээлдүүлэгчийн хувьд төлбөрийн чадвартай боловч үйл ажиллагаанд нь түр зуурын санхүүгийн хүндрэл гарсан банкинд барьцаат зээл олгодог. Монголбанк тухайн банкийг өөрийн үйл ажиллагааны үр дүнд хүндрэлээс богино хугацаанд гарч чадна гэж үзсэн, зээлийн барьцаа нь Монголбанкны шаардлагыг хангасан тохиолдолд 90 хүртэл хоногийн хугацаатай барьцаат зээл олгодог. Монголбанк барьцаат зээлийн хүүг бодлогын хүүтэй уялдуулсан хүүний бүтцийг баталсан бөгөөд 2010 оны эцсийн байдлаар барьцаат зээлийн хүү бодлогын хүү дээр нэмэх нь 8 нэгж хувь байна. Тайлант онд Монголбанк 4 тэрбум төгрөгийн барьцаат зээл нэмж олгосон бөгөөд барьцаат зээлийн үлдэгдэл оны эцэст 120 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь “Банк дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийн дагуу Засгийн газрын өмнөөс олгосон зээлийн үлдэгдэл юм. Энэхүү зээлийн үлдэгдлийг засгийн газрын бондоор солих ажлыг эхлүүлээд байна. Тайлант онд Монголбанк 18.3 тэрбум төгрөгийн чанаргүй болсон барьцаат зээлийг банкны активаар төлүүлэх арга хэмжээ авлаа.

Дамжуулан олгосон төслийн зээлүүд

Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл

Азийн хөгжлийн банкны "Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл"-ийн хүрээнд Голомт, Эрэл банкуудад зээл олгов. Монголбанк ажлын байр нэмэгдүүлэх төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрээс 2010 онд нийт 536.8 сая төгрөгийн зээлийг дээрх 2 банкинд дамжуулан олгож, банкуудын зээлийн өрийн үлдэгдэл оны эцсийн байдлаар 684.8 сая төгрөг байв.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ХБНГУ-ын Сэргээн босголт, хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслийн зээлийн тухай

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих зорилго бүхий хоёр хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Монгол Улс 1 дүгээр хөтөлбөрийн хүрээнд анх 10.0 сая марк буюу 5.1 сая евро, 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд 3.6 сая евро, нийт 8.7 сая еврогийн зээлийг авсан. Төслийн үндсэн эх үүсвэрийг бүрэн ашиглаж дууссан бөгөөд банкуудаас эргэн төлөгдсөн зээлийн эх үүсвэрээр төслийн зориулалтын дагуу дахин зээл олгож ирэв. 2010 онд төсөлд оролцогч банкуудад 775.2 мянган еврогийн зээлийг дамжуулан олгож, банкуудын төслийн зээлийн өрийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 2.9 сая евро болсон байна.

Засгийн газрын цэвэр зээл

Тайлант оны эцэст банкны салбарын нэгдсэн дүнгээр Засгийн газраас авах авлага 633.8 тэрбум төгрөг, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө 1225.2 тэрбум төгрөг болж, Засгийн газрын цэвэр зээлийн хэмжээ -591.4 тэрбум төгрөг болсон. Энэ дүнг 2009 оны мөн үетэй харьцуулбал төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хадгаламж 66.0 тэрбум төгрөгөөр, Засгийн газраас авах авлага 211.6 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Зураг35. Банкны салбар дахь засгийн газрын цэвэр зээл (тэрбум төгрөгөөр)



Эх үүсвэр: Монголбанк

Засгийн газраас авах авлагын талаар

Засгийн газраас авах авлага Монголбанк болон банкуудын тэнцлийн нэгдсэн дүнгээр тайлант улирлын эцэст 633.8 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны эцсээс 211.6 тэрбум төгрөгөөр өссөн дүн байна. Тайлант оны 3 дугаар сард Монголбанк Сангийн яамтай Зоос банкинд олгосон зээлийг үнэт цаасжуулах бондын гэрээ, Төрийн албан хаагчийн 4000 орон сууцны санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх бондын гэрээнүүдийг байгуулж эдгээр гэрээний хүрээнд нийт 63.0 тэрбум төгрөгийн дунд болон урт хугацаатай Засгийн газрын үнэт цаас худалдан авсан байна. Засгийн газраас авах авлага нь өмнөх оныхоос бүтцийн хувьд өөрчлөгдсөн байна. Тухайлбал, 2009 оны эцэст нийт авлагын зөвхөн 2.1 хувийг арилжааны банкуудын Засгийн газраас авах авлага эзэлж байсан бол энэ үзүүлэлт нь 2010 оны эцэст 12.5 хувьд хүрсэн байна. 2010 оны эцэст Засгийн газраас авах банкуудын авлагын 1.5 хувийг банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн болон хойшлогдсон татвар, 4.9 хувийг хуримтлуулж тооцсон хүүний авлага эзэлж байгаа бол үлдсэн 93.6 хувийг Засгийн газрын богино болон дунд хугацаатай үнэт цаас эзэлж байна. Богино хугацаат үнэт цаас нь Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкууд дээр байршиж, дунд хугацаат үнэт цаас нь ХААН, Худалдаа хөгжлийн банкууд дээр байршиж байна.

Засгийн газрын нэгдсэн төсвийн талаар

Банкны систем дэх улсын төсвийн хөрөнгө болон харилцах, хадгаламж 2010 оны эцэст 1225.2 тэрбум төгрөг болов. Нийт үлдэгдлийн 65.5 хувь нь Монголбанкинд, 34.5 хувь нь банкуудад байршиж байна. Нийт төсвийн хөрөнгийн 83.6 хувь нь Төрийн сангийн нэгдсэн данс болон Засгийн газрын харилцах дансны хөрөнгө, 1.5 хувь нь хадгаламж, 14.4 хувь нь Засгийн газрын санхүүжилтийн хөрөнгө, 0.5 хувь нь орон нутгийн төсвийн хөрөнгө юм.

2.3 Мөнгөний үзүүлэлтүүдийн байдал

Мөнгөний нийлүүлэлт 2010 оны эцэст өмнөх оны мөн үеэс 62.5 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өсч 4.7 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний агрегатуудаар нь задлан харвал бараг мөнгөний жилийн өсөлт 58.0 хувь байгаа бөгөөд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 71.9 хувь болно. Тэр дундаа төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт 62.2 хувь буюу бараг мөнгөний өсөлтийн 59 хувь, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 43 хувь, валютын харилцах, хадгаламж нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 29 хувийг бүрдүүлж байгаа бол төгрөгийн харилцах 6.9 хувийг, үлдсэн нь гүйлгээнд байгаа мөнгөний өсөлт юм. Бараг мөнгө 2010 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 58.0 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өссөн бол харин М1 мөнгө 77.8 хувиар буюу 506.4 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг36. М2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)



Эх үүсвэр: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлтийн хандлагыг авч үзвэл М1 мөнгөний жилийн өсөлтийн хурд тайлант онд эрчимтэй өссөөр оны эцэст 77.8 хувьд хүрэв. М1 мөнгөний жилийн өсөлт 2010 оны туршид банкны системийн хэмжээгээр харилцах дансдын үлдэгдэл хурдацтай өссөнтэй холбоотой. Харин бараг мөнгөний өсөлт 2009 оны 2 дугаар хагасаас 2010 оны эхний хагас жил хүртэл эрчимтэй байсан бол 2 дугаар хагасаас бага зэрэг саарч, оны эцэст дахин огцом өсч 58.0 хувьд хүрээд байна. Энэхүү өсөлтийн 59.3 хувийг төгрөгийн хадгаламж дангаараа эзэлж байгаа бол 30.4 хувийг валютын харилцах, үлдсэн 10.2 хувийг валютын хадгаламжийн өсөлт эзэлж байна. Бараг мөнгөний өсөлт, түүн дотроо төгрөгийн хадгаламжийн өсөлт нь 2010 оны 8 дугаар сарыг эс тооцвол 2 дугаар улирлаас эхлэн эерэг байна.

Хүснэгт12. Мөнгөний үзүүлэлт (жилийн эцсийн байдлаар, тэрбум төг, сүүлийн 12 сарын өөрчлөлт, %)

Мөнгөний үзүүлэлт	2005 он		2009 он		2010 он			
	жилийн Δ%	ДҮН	жилийн Δ%	ДҮН	жилийн Δ%	ДҮН	жилийн Δ-д эзлэх %	М2-т эзлэх хувь
1 Бага мөнгө (М1) = a+b	***21.6%***	***269.1***	***0.6%***	***651.2***	***77.8%***	***1,157.6***	***28.1%***	***24.7%***
a. Банкнаас гадуурх мөнгө	6.2%	152.4	-13.3%	285.0	36.2%	388.2	5.7%	8.3%
b. Төгрөгийн харилцах	50.0%	116.8	15.0%	366.3	110.1%	769.4	22.4%	16.4%
2 Бараг мөнгө = c+d	***39.2%***	***871.0***	***37.4%***	***2,228.8***	***58.0%***	***3,522.4***	***71.9%***	***75.3%***
c. Нийт хадгаламж = i+ii	29.8%	671.7	38.7%	1,856.4	48.5%	2,756.2	50.0%	58.9%
i.Төгрөгийн хадгаламж	*41.6%*	*426.0*	*37.3%*	*1,234.3*	*62.2%*	*2,001.6*	*42.6%*	*42.8%*
ii.Валютын хадгаламж	*13.5%*	*245.7*	*41.3%*	*622.1*	*21.3%*	*754.6*	*7.4%*	*16.1%*
d. Валютын харилцах	84.0%	199.3	31.2%	372.4	105.8%	766.1	21.9%	16.4%
Нийт мөнгө (М2) = (1)+(2)	**34.6%**	**1,140.1**	**26.9%**	**2,880.0**	**62.5%**	**4,680.0**		

Эх үүсвэр: Монголбанк, сарын статистикийн мэдээлэл

Тайлант онд хөрөнгийн дотогшлох урсгалаас шалтгаалсан төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарч, түүний ирээдүйн хүлээлттэй холбоотойгоор төгрөгийн харилцах, хадгаламжийн М2 мөнгөнд эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад өссөөр байна.

Зураг37. М2 мөнгөний бүтэц (М2 мөнгөнд эзлэх хувь)

Эх үүсвэр: Монголбанк

Тайлант онд төгрөгийн харилцах, хадгаламжийн нийт мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь өмнөх онуудтай харьцуулахад өндөр байгаа нь төгрөгийн харилцахын нийт мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь 4.0 нэгж хувиар өссөнөөр тайлбарлагдахаар байна. Харин банкнаас гадуурх мөнгө 2010 оны 12 дугаар сарын байдлаар жилийн 36.2 хувийн өсөлттэй байгаа ч нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлт илүү өндөр байгаа учир нийт мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь буурсан байна.

Зураг38. М2 мөнгө, түүний бүтэц (жилийн өсөлт)



Эх үүсвэр: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг байршуулалт талаас нь авч үзвэл 2009 оны сүүлийн хагасаас гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт нь дотоод цэвэр актив (ДЦА)-ын өсөлтөөс давж байгаа нь төгрөгийн өгөөж өссөн, дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ өсч экспортын орлого нэмэгдсэн, байгалийн баялгийн томоохон төслүүд батлагдсанаас үүдэн хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэнтэй холбоотой байна.

М1 мөнгө

Тайлант оны эцэст М1 мөнгө өмнөх оны мөн үеэс 77.8 хувь буюу 506.4 тэрбум төгрөгөөр өсч 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 24.7 хувь байна.

Зураг39. Мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт, өмнөх оны мөн үе=100%



Эх үүсвэр: Монголбанк

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 147.9 тэрбум төгрөг буюу 39.8 хувиар өсч 519.7 тэрбум төгрөгт хүрлээ. Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 74.7 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.9 нэгж хувиар бага юм.

Гадаад болон дотоод цэвэр актив

2010 оны 12 дугаар сард Бараг мөнгө 578.5 тэрбум төгрөгөөр өссөнөөр нийт активийн бүрэлдэхүүн болох гадаад цэвэр активыг өмнөх сартай харьцуулахад 587.6 тэрбум төгрөгөөр өсгөхөд хүргэсэн байна. Энэ нь нийт активын өөрчлөлтийн 73.3 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 26.7 хувь нь дотоодын зээлийн өөрчлөлт байна. Дотоод цэвэр актив (ДЦА) 2010 оны эцэст өмнөх оноос 25.4 хувиар өсчээ.

Зураг40. ГЦА, ДЦА (тэрбум төгрөгөөр), М2-ийн жилийн өсөлт, хувиар, баруун тэнхлэг



Эх үүсвэр: Монголбанк

Нийт активын өөрчлөлтийн дийлэнхийг гадаад цэвэр актив эзэлж байна. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хөдөлгөөнийг сааруулах зорилгоор Монголбанк гадаад валютын захаас 2010 онд нийт 1.2 их наяд төгрөгтэй тэнцэх ам.доллар худалдан авч мөнгөний захад төгрөг нийлүүлснээр төгрөгийн харилцах, хадгаламжаар дамжин мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, гадаад цэвэр активийг өсгөлөө.

Бараг мөнгө

Бараг мөнгө 2010 онд 58.0 хувиар өсч 3.5 их наяд төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний нийлүүлэлтийн 75.3 хувийг эзэлж байна. Бараг мөнгөний бүтцээс харахад төгрөгийн хадгаламж оны эхнээс 62.2 хувь буюу 767.3 тэрбум төгрөгөөр, гадаад валютын харилцах хадгаламж 52.9 хувь буюу 526.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг41. Бараг мөнгө, түүний бүтэц (жилийн өөрчлөлт)



Эх үүсвэр: Монголбанк

Мөнгөний үржүүлэгч ба эргэлтийн хурд

Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний *эргэлтийн хурд* өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 нэгжээр буурч 1.8 боллоо. Нэрлэсэн ДНБ-ий өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөөс их байсан учир ийм үзүүлэлт тооцоо гарч байна.

Зураг42. Мөнгөний эргэлтийн хурд болон мөнгөний үржүүлэгч

Мөнгөний үржүүлэгч өндөр байх нь банкууд бага хэмжээний нөөц мөнгөөр их хэмжээний мөнгөний нийлүүлэлтийг бий болгож чадаж байгааг илэрхийлдэг. Өмнөх оны 2 дугаар хагасаас эхлэн *мөнгөний үржүүлэгч* өссөөр тайлант онд дунджаар 4.7 гарсан байна. Энэ нь өмнөх оны дундажтай харьцуулбал 0.74 нэгжээр буурсан үзүүлэлт байлаа. Нөөц мөнгө 4.7 дахин үржигдэж эдийн засагт нийлүүлэгдэж байгааг илэрхийлж байгаа юм.

2.4 Банк хоорондын мөнгөний зах

Банк хоорондын зах дээр овернайт зээл, репо санхүүжилт, ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа, банк хоорондын зээл, хадгаламжийн хэлцлүүд хийгдэж байна. 2010 оны эхний хагаст банк хоорондын захын идэвх сул байсан бөгөөд оны сүүлийн хагаст захын үйл ажиллагаа идэвхжсэн. 2010 оны эхэнд нийт арилжааны дүн 80.5 тэрбум төгрөг байсан бол 12 дугаар сард энэ дүн 197.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 277.8 тэрбум төгрөг болсон байна.

Зураг43. Банк хоорондын зах дээр хийгдсэн нийт арилжааны дүн, илүүдэл нөөц



Банк хоорондын захын хүү 2010 оны 1 дүгээр улирлын эцэст 7.22 хувь байсан бол 2 дугаар улирлын эцэст 10.42 хувь, 3 дугаар улирлын эцэст 10.33 хувь, оны эцэст 9.45 хувь болсон байна. Банкууд бүгд эх үүсвэр сайтай байсан учир банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү жилийн турш харьцангуй нам түвшинд байх нөхцөл бүрэлджээ.

Зураг44. Банк хоорондын захын ЖДХ, банкуудын илүүдэл нөөц



III. ВАЛЮТЫН ХАНШИЙН БОДЛОГО, НӨӨЦИЙН УДИРДЛАГА

3.1 Валютын ханшийн бодлого

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөөр тодорхойлогдон уян хатан тогтож байх зарчмыг баримталж, дэлхийн санхүүгийн зах зээлийн болон гадаад худалдааны нөхцлийн огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан ханш, мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан зохицуулах, гадаад валютын албан нөөцийг хамгаалах бодлого хэрэгжүүлэв.

Гадаад валютын дотогшлох цэвэр урсгал 2010 онд 1.6 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрч, өмнөх оноос 5.8 дахин өслөө. Үүнээс америк долларынх 9.9 дахин өссөн бол гадаад худалдааны нөхцөлийн индекс 15.2 хувиар сайжирсан байна.

Зураг45. Гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000.01=100/



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт13. Гадаад худалдааны тэнцэл

	Эхний 12 сар		Δ%
	2009	2010	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	**4,023.1**	**6,177.1**	**53.5%**
▪ Валютын төлбөртэй бараа	3,704.1	5,867.2	58.4%
Экспорт	**1,885.4**	**2,899.2**	**53.8%**
▪ Валютын төлбөртэй бараа	1,868.5	2,895.7	55.0%
Импорт	**2,137.7**	**3,277.9**	**53.3%**
▪ Валютын төлбөртэй бараа	1,835.7	2,971.5	61.9%
Гадаад худалдааны тэнцэл	**-252.3**	**-378.7**	**50.1%**
▪ Валютын төлбөртэй бараа	32.8	-75.9	

Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Барааны гадаад худалдааны алдагдал 2010 оны байдлаар 50.1 хувиар өссөнөөс гадна валютын төлбөртэй барааны гадаад худалдааны тэнцэл 2009 онд 32.8 сая ам.долларын ашигтай байснаа 2010 онд 75.9 сая ам.долларын алдагдалтай болжээ. Урсгал тэнцлийн алдагдал 931.5 сая ам.долларт хүрч 2009 оноос 2.7 дахин өссөн зэрэг макро эдийн засгийн суурь нөхцлүүд нь төгрөгийн ханш хэт хурдтай, огцом чангарах дарамт бий болгосон юм. Иймд Монголбанк валютын дотоодын захад оролцон:

- ам.долларыг татан,
- төгрөгийн тодорхой хэсгийг ТБҮЦ-аар эргүүлэн татах бодлого баримталж,
- инфляци үүсэх дарамтгүй байх нөхцөл бүрдүүлэн,
- ханшийн тогтвортой байдлыг хангаж,
- гадаад валютын улсын нөөцийг түүхэн дээд түвшинд буюу 2287.73 сая ам.долларт хүргэн нэмэгдүүлсэн.

Зураг46. Урсгал тэнцэл, түүний ДНБ-д эзлэх хувь

Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Монголбанк гадаад валютын дотоод дахь зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, төгрөгийн ханш уян хатан тогтох нөхцлийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээ авлаа:

1. Гадаад валютын банк хоорондын захын арилжааны цахим системийг нэвтрүүлж, Блүмберг системд "MGFX" цонхыг үүсгэн, холбогдох гэрээг банкуудтай байгуулж ажилласан нь захын үр ашгийг нэмэгдүүлэх, арилжааг идэвхжүүлэх, банк хоорондын захын нээлттэй, ил тод байдал, мэдээллийн солилцоо, хүртээмжийг сайжруулах зэрэг ач холбогдолтой болов. Үүний дүнд банк хоорондын арилжаа өмнөх оноос 128.3 хувиар өсч, 358.7 сая ам.долларт хүрсэн бөгөөд уг арилжааны 78.3 хувийг MGFX цахим цонхоор дамжуулан хийжээ.

2. "Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах журам, заавар", "Валютын своп, форвард хэлцлийн гэрээ, заавар" зэрэг валютын дотоодын захын үйл ажиллагаанд холбогдох журам, зааврыг шинээр боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласнаар Монголбанкинд байршуулж буй гадаад валютын хадгаламжийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, банк хоорондын захад санхүүгийн үүсмэл хэрэгслийг хөгжүүлэх, түүний хэрэглээг нэмэгдүүлэх, улмаар эцсийн хэрэглэгч нь ханшийн эрсдэлээс хамгаалагдах зэрэг дэвшилтэд хүрлээ. Түүнчлэн "Төгрөгийн гадаад валюттай харьцах албан ханш тооцох заавар", "Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш тооцох журам"-д өөрчлөлт оруулснаар Монголбанк банк хоорондын захын тухайн өдрийн хаалтын ханшийг хугацааны хоцрогдолгүй зарладаг болов.

3. Гадаад валютын дотогшлох урсгал давамгайлж буйтай уялдуулан гадаад валютын дуудлага худалдаагаар ирүүлэх банкны нэгж саналын хэмжээг 4 дахин нэмэгдүүлж, нэг банк 20.0 сая ам.долларын санал ирүүлэх боломжийг бүрдүүлэн төгрөгийн ханшийн хэлбэлзлийг хязгаарлах нөхцлийг сайжруулсан.

Ханшийн тойм

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс 13.0 хувиар чангарч 1257.18 төгрөгт хүрсэн байна. Хэдийгээр жилийн туршид төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарах хандлагатай байсан ч, жилийн нийт хоногийн 90.5 хувьд нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл 0.4 хувиас хэтрээгүй байна. Жилийн туршид зөвхөн 3 өдөр ханш нэгээс дээш хувиар хэлбэлзэж байв. 2010 онд төгрөгийн бодит үйлчилж буй ханш[3] 31.8 хувиар, нэрлэсэн үйлчилж буй ханш 16.8 хувиар тус тус чангарчээ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2009 оны 4 дүгээр сараас хойш 21 сарын турш тогтвортой байна.

Зураг47. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханшийн хэлбэлзэл



Эх сурвалж: Монголбанк

Зураг48. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдөр тутмын хэлбэлзлийн давтамж



Эх сурвалж: Монголбанк

Зураг49. Төгрөгийн бодит үйлчилж буй ханш дахь инфляци ба нэрлэсэн үйлчилж буй ханшийн нөлөө



Эх сурвалж: Монголбанк

Зураг50. Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш



Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ2. Валютын дотоодын зах, гадаад валютын дуудлага худалдаа

[3] Энд төлбөрийн валютаар жигнэж тооцсон нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш.

Хямралын дараа дэлхийн эдийн засаг, ялангуяа Азийн эдийн засаг сэргэж суурь металл, эрчим хүчний эрдэс түүхий эдийн эрэлт нэмэгдэж, зах зээлийн үнэ эргэн өслөө. Гадаад тэнцэл тогтвортой, гадаад худалдааны нөхцөл таатай, эдийн засгийн цаашдын өсөлтийн хүлээлт өндөр байгаа учраас гадаад валютын дотогшлох урсгал 2010 онд нэмэгдлээ. Гадаад валютын дотогшлох урсгал нь экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээл, багцын буюу санхүүгийн хөрөнгө оруулалт, бэлэн мөнгө болон харилцах хэлбэрээр ирж байна. Үүнд манай орны эдийн засгийн таатай орчноос хамааран хөрөнгийн урсгал нь бага өгөөжтэй зах зээлээс өндөр өгөөжтэй зах зээлд шилждэг зарчмаар арилжааны банкууд болон томоохон аж ахуйн нэгжүүдийн гадаадын зах зээлээс босгосон мөнгө багагүй хувийг эзэлж байна.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөөр тодорхойлогдон уян хатан тогтож байх зарчмыг ханган, гадаад валютын дотоодын зах дахь Монголбанкны оролцоог ил тод, нээлттэй хэрэгжүүлж, валютын дотоодын захад 2009 онд нэвтрүүлсэн гадаад валютын дуудлага худалдааг 2010 онд үргэлжлүүллээ. Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд банкууд гадаад валют худалдан авах, худалдах саналаа долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт ирүүлж оролцдог бөгөөд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд нь өөрийн харилцагч банкаар дамжуулан дуудлага худалдаанд оролцох боломжтой байдаг.

Зах зээлийн хэмжээ, цар хүрээ эрс нэмэгдэж байгаатай уялдан Монголбанк 2010 оны 8 дугаар сарын 10-ны өдөр дуудлага худалдаанд оролцох банкны нэгж саналын доод хэмжээг 200.0 мянга, дээд хэмжээг 2.0 сая ам.доллар болгон нэмэгдүүлсэн бол 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдөр дээд хэмжээг 4.0 сая ам.доллар болгон дахин нэмэгдүүлснээр нийт 20.0 сая ам.доллар худалдах, худалдан авах саналыг ирүүлэх боломжтой болсон юм. Монголбанк 2010 онд нийт 103 удаагийн дуудлага худалдаагаар банкуудын ам.доллар худалдах саналын 56 хувь буюу 678.7 сая ам.долларыг худалдан авчээ. Ингэснээр төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг ханган, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн.

3.2 Гадаад валютын нөөцийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа түүний найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг урьдын адил баримтлан ажиллалаа. 2010 онд дараах арга хэмжээнүүдийг авсан болно. Үүнд:

1. Монголбанк гадаад валютын улсын нөөцийн бүтцийг 2008 оноос Монгол Улсын гадаад төлбөр тооцоо, импортын болон экспортын төлбөртэй уялдуулан тодорхойлдог болсон. 2010 онд үүнийг илүү боловсронгуй болгож, гадаад

валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулан, гадаад төлбөр тооцоог ханшийн эрсдэлгүйгээр гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлсэн.

2. Хөрөнгө оруулалтын болон харилцагчийн эрсдэлээс сэргийлэх үүднээс гадаад валютын улсын нөөцийг АНУ-ын Засгийн газрын үнэт цаас, АНУ, ХБНГУ, Япон, Их Британи, Швейцарь, Шинэ Зеландын төв банкууд, Олон улсын төлбөр тооцооны банкны үнэт цаас, харилцах, хадгаламж, "АА"-аас дээш зэрэглэл бүхий гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын хадгаламжид байршуулав. Үүний үр дүнд Засгийн газрын гадаад орон руу гүйцэтгэх аливаа төлбөр тооцоог тухай бүр саадгүй гүйцэтгэсний зэрэгцээ гадаад валютын улсын нөөцийн найдвартай байдлыг хангасан болно.

Зураг51. Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээтэй байдал /2006-2010/



Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын улсын нөөц 2010 оны 12 дугаар сарын гүйтгэтгэлээр өмнөх оны мөн үеэс 72 хувиар буюу 960.3 сая ам.доллараар өсч 2287.73 ам.долларт хүрч Монгол Улсын импортын 26.17 долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд хүрсэн байна. Ингэж өсөх нөхцөл бүрдүүлсэн хүчин зүйлсийг дурьдвал:

- Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаагаар банкуудаас 678.7 сая ам.долларыг худалдан авсан;
- Банкуудын Монголбанк дахь гадаад валютын харилцах, хадгаламжийн үлдэгдэл 195.6 сая ам.доллараар нэмэгдсэн;
- Алт цэвэршүүлэлтийн үйл ажиллагаагаар 85.47 сая ам.доллар орлогодсон;
- "Оюу-Толгой" төслийн 50.0 сая ам.долларын урьдчилгаа төлбөр орж ирсэн;
- Гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд Монголбанк харилцах, хадгаламжийн хүүгийн орлогоос нийт 1.61 сая ам.доллар, богино хугацаат үнэт цаасны хөрөнгө оруулалтаас 2.69 сая ам.доллар, мөнгөжсөн алтны арилжаанаас 4.48 сая ам.доллар,

нийт 8.78 сая ам.доллар ашиг олсон байна. Гадаад валютын улсын нөөц хөрөнгө оруулалтын, хүүгийн орлого 2009 оноос 2.99 сая ам.долларaар буурсан нь нөөцийн багцад байсан АНУ-ын Засгийн газрын урт хугацааны үнэт цаасны багцын хугацаа дуусан болон голлох валютуудын өгөөж буурсантай холбоотой байна.

Гадаад валютын цэвэр албан нөөцийн өсөлтийн 80.5 хувийг ам.долларын, 8.6 хувийг еврогийн, 0.6 хувийг паунд стерлингийн бодит өөрчлөлт тус тус эзэлж байв. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авах юм. Монголбанк 2010 онд дотоодоос худалдан авах алтны үнийн хөнгөлөлтийг хэвээр хадгалах бодлого баримтлан ажиллав. Тайлант онд Монголбанк алт олборлогч 105 гаруй аж ахуйн нэгж, давхардсан тоогоор 3 иргэдээс нийт 2.1 тонн алтыг 101.31 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь тухайн хугацаанд Стандартчилал, хэмжил зүйн газрын Сорьцын хэлтсээр сорьц тогтоолгосон нийт алтны 31.5 хувийг, Бороо гоулд ХХК-ийн сорьц тогтоолгосон алтыг хассаны 81.8 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад харгалзан 16.3 хувь, 15.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант хугацаанд алт олборлолтын хэмжээ өмнөх оноос 3.8 тонн буюу 38 хувиар буурсан тул алт тушаалтын хэмжээ 2009 онтой харьцуулахад 2.9 тонноор буюу 58 хувиар буурахад нөлөөлжээ.

Зураг52. Монголбанкинд тушаасан алтны хэмжээ /бохир жин, тонноор/



Эх сурвалж: Монголбанк

Зураг53. Монголбанкны алт цэвэршүүлэлт /бохир жин, тонноор/



Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөцийн удирдлагад эрсдэлийн удирдлагын урт хугацаанд баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлон, нөөцийн удирдлагын хэрэгжилтэнд өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд Монголбанкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг батлан мөрдүүлж ажиллалаа. Ерөнхий бүтцийн хүрээнд гадаад валютын улсын нөөцийн активын бүтэц, гадаад валютын бүтэц, багцын бүтэц, урт хугацаат хөрөнгө оруулалтын

зохистой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлов. Мөн гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн байдлыг байнга ажиглан холбогдох мэдээ тайлан бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

Санхүүгийн зах зээлийн байдал 2010 онд бүрэн тогтворжоогүй байсан тул нөөцийн найдвартай байдлыг хангах зорилгоор бэлэн валют, биет хэлбэрээр байршуулсан мөнгөжсөн алт, Төв банкууд дахь харилцах данс болон хадгаламж, Олон улсын санхүүгийн байгууллагуудын хадгаламж, АНУ ба ХБНГУ-ын Засгийн газрын богино хугацаат үнэт цаас, Олон улсын төлбөр тооцооны банкны богино хугацаат үнэт цаас зэрэг зээлийн эрсдэлгүй хэрэгслүүдэд хөрөнгө оруулах чиглэлийг баримталж ажиллалаа. Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад зэрэглэл харгалзахгүйгээр баталгаагүй хөрөнгө байршуулахгүй байх бодлогыг үргэлжлүүлсэн.

Гадаад валютын улсын нөөцийн хэмжээ нэмэгдсэн, богино хугацаат хөрвөх чадвар бүхий нөөцийн шаардлага харьцангуй багассан зэрэг нь нөөцийг илүү урт хугацаат хөрөнгө оруулалтад оруулах боломжийг бүрдүүлсэн ч АНУ-ын Холбооны нөөцийн банк, Европын холбооны төв банк зэрэг Төв банкуудын хүүний түвшин бага хэвээр байгаа нь хүүний эрсдэлийг нэмэгдүүлнэ гэж үзэн богино хугацаатай хөрөнгө оруулалтууд байршуулсан болно.

IV. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ

4.1 Банкны салбарын үзүүлэлтүүд

Монгол Улсад 2010 оны эцсийн байдлаар 14 банк, 1070 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эрх хүлээн авагч томилогдсон 2 банк байна. Банкны салбарын нийт активын хэмжээ 6.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 43 хувь буюу 1.9 их наяд төгрөгөөр өсөн ДНБ-ий 75.3 хувьд хүрлээ.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 2010 оны эцсийн байдлаар 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны эцсээс 2.2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд богино хугацаат хөрөнгө оруулалтын 96 хувийг төв банкны үнэт цаас эзэлж байна. 2010 оны эцсийн байдлаар ТБҮЦ 1.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцсээс 710.5 тэрбум төгрөгөөр буюу 2.8 дахин өссөн байна. Банкуудын эх үүсвэр нэмэгдэж, тэр дундаа харилцахын үлдэгдэл хурдан өссөн нь банкуудыг богино хугацаатай, хөрвөх чадвар өндөртэй активаа нэмэгдүүлэх, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа сайжруулах шийдвэрт хүргэжээ.

Монгол Улсын Их Хурлаас “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-д 2010 оны 07 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулж банк хоорондын захаас болон гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн мөнгөн хадгаламж, харилцах дансны үлдэгдлийг баталгаанд үл хамааруулахаар заасан. Банк хоорондын захын үйл ажиллагаа оны гуравдугаар улирлаас эхлэн тэлж эхэлсэн ба нийт тэнцэл 200 тэрбум төгрөгөөс тогтмол давж байлаа.

Зээлийн өрийн үлдэгдэл 3.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.4 их наяд төгрөгөөр өсчээ. Өнгөрсөн оны эцэст банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нийт зээлийн 20 хувь болж 544.1 тэрбум төгрөгт хүрэн зээлийн багцын чанар муудаж байсан бол тайлант оны эцэст 6.7 хувь болж[4], 209.6 тэрбум төгрөг болж буурлаа.

Зураг54. Чанаргүй зээл, эдийн засгийн салбарын ангиллаар



Нийт зээлийн бүтцийг салбараар авч үзвэл худалдааны салбар 18 хувь, боловсруулах 14 хувь, уул уурхай 12 хувь, барилга 11 хувийг эзэлж байгаа ба тухайн салбаруудын нийт зээлд эзлэх хувь хэмжээ тайлант онд буурчээ. Харин банкуудын ипотекийн зээлийн хэмжээ нэмэгдэж, улмаар нийт зээлийн 14 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээл эзэлж байна. 2010 оны эцсийн байдлаар үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээл нийт зээлийн 7.1 хувийг эзэлж байжээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд зээлийн хүүг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тусгасны дагуу Монголбанкнаас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд өнгөрсөн оны эцэст төгрөгийн зээлийн хүү 20.8 хувь, гадаад валютын зээлийн хүү 16.5 хувь байсан бол тайлант оны эцсийн байдлаар төгрөгийн зээлийн хүү 17.9 хувь, гадаад валютын зээлийн хүү 12.6 хувьд тус тус хүрлээ.

[4] Эрх хүлээн авагч томилогдсон Анод, Зоос банкуудын чанаргүй зээлийн хэмжээг оруулан тооцвол уг харьцаа 11.6 хувьд хүрч чанаргүй зээлийн хэмжээ 381.3 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа

Зураг55. Банкны салбарын актив ба ДНБ-д эзлэх хувь хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Зураг56. Мөнгөн хөрөнгө ба төв банкны үнэт цаас /их наяд төгрөгөөр/



Зураг57. Төлбөр тургэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Зураг58. Банкны салбарын зээлийн чанар



* 2010 оны чанаргүй зээлээс ЭХА томилогдсон банкуудын үзүүлэлтийг хасч тооцсон

Зураг59. Зээлийн өрийн үлдэгдэл, салбараар



Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 1.7 саяд хүрч өмнөх оны эцсийн байдлаас 20.4 хувиар буюу 3 саяар өсчээ. Хадгаламж эзэмшигчид нэмэгдэхийн хирээр банкны салбарын эх үүсвэрийн хэмжээ өсч байгаа бөгөөд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 5.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн. Нийт хадгаламжийн хэмжээ 41.4 хувиар буюу 0.8 их наяд төгрөгөөр өсч 2.8 их наяд төгрөгт, нийт харилцах 1.9 дахин өсч 0.8 их наяд төгрөгөөр өсч 1.7 их наяд төгрөгт хүрсэн нь иргэдийн банкинд итгэх итгэл сайжирсан, төрөөс харилцах, хадгаламжид баталгаа гаргасан, эдийн засаг дахь хөрөнгийн орох урсгал нэмэгдэж байгаатай холбоотой юм. Нийт хадгаламжийн өсөлтийн (823.7 тэрбум төгрөг) 70.5 хувь буюу 580.4 тэрбум төгрөг нь хугацаатай хадгаламж, 29.5 хувь болох 243.3 тэрбум төгрөг нь хугацаагүй хадгаламж байгаа нь эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаа нэмэгдэх, урт хугацаат хөрөнгө оруулалтад эх үүсвэр байршуулалтыг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлөх боломжтойг харуулж байна.

Хадгаламжийг бүтцээр нь аваад үзвэл 87.3 хувь буюу 1.8 их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж, 6.4 хувь буюу 0.2 их наяд төгрөг нь хувийн секторын хадгаламж, үлдэх 6.4 хувь нь төрийн байгууллага, гадаадын оршин суугч, оршин суугч бус болон бусад этгээдийн хадгаламж эзэлж байна. Харилцах, хадгаламж нэмэгдсэнтэй холбоотойгоор бусад эх үүсвэр татах шаардлага багассанаас оны эцсийн байдлаар гадаадын банкнаас авсан зээлийн хэмжээ 180.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 36.7 хувиар буюу 104.9 тэрбум төгрөгөөр буурчээ.

Банкны эрсдэл даах чадварын илэрхийлэл болсон өөрийн хөрөнгийн хэмжээ оны эцсийн байдлаар 631.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.6 дахин буюу 454.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ ийнхүү нэмэгдсэн нь банкуудын ашигт ажиллагаа сайжирсантай холбоотой байлаа. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжирч нийт цэвэр ашгийн хэмжээ тайлант оны эцсийн байдлаар 70.9 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт хүүгийн орлогын хэмжээ оны эцсийн байдлаар 533.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 83.7 тэрбум төгрөгөөр, хүүгийн зардал 332.1 тэрбум төгрөгт хүрч өмнө оны эцсийн байдлаас 16.9 тэрбум төгрөгөөр өсчээ. Хүүгийн орлогын өсөлтийн үндсэн хүчин зүйл нь хувийн секторт олгосон зээлийн хүүгийн орлого болон төв банкны үнэт цааснаас хуримтлуулсан орлогууд эзэлж байна.

Тайлант онд банкны салбарт харилцагч, хадгаламж эзэмшигчдийн тоо нэмэгдэж банкинд итгэх итгэл сайжирсан, эдийн засаг дахь хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэн зэрэг нь эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлсэн бөгөөд тухайн эх үүсвэрийг банкууд хүлээж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилготойгоор, эх үүсвэрийн хугацаанаас хамааралтайгаар, богино хугацаанд татан авах боломжтой хөрвөх чадвар өндөртэй активт байршуулсан нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулан гэнэтийн гарах урсгалд хөрвөх чадварын эрсдэлийг бууруулсан үйл ажиллагаа боллоо.

Банкууд тайлант хугацаанд зээл олголтыг нэмэгдүүлэхээс илүүтэйгээр өмнөх хугацаанд олгосон зээлийн чанарт анхаарч ажиллан чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, төвлөрлийн эрсдэлийг багасгах, эргэн төлөлтийг сайжруулах, олгосон зээлийн хугацаа сунгалтыг оновчтой болгох зэрэг арга хэмжээг авч ажиллалаа. Тайлант онд нийт чанаргүй зээлийн хэмжээ багасч, эрсдэлийн сангийн зардал бууран, зээлийн эргэн төлөлт сайжирснаар хүүгийн орлогын хэмжээ өсч банкуудын ашигт ажиллагаа сайжран, өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт сайжирч, банкуудын эрсдэл даах чадвар нэмэгдлээ.

Зураг60. Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ */тэрбум төгрөг, хувиар/*



Зураг61. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц */хувиар/*



Зураг62. Ашигт ажиллагааны үзүүлэлт /хувиар/



**WHD – өмнөд ба хойд америк тивийн орнууд (Western hemisphere countries), ED – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд (emerging and developing economies), OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд(organization for economic cooperation and development), G20 - 20 орнууд (group of 20 countries), EUR-европын орнууд (European countries), APD – ази, далайн орнууд(asian and pacific countries)*

Зохистой харьцааны үзүүлэлтүүд

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж банкуудын эрсдэлийг илүү бодитой тодорхойлдог болсон. Журмын дагуу тооцсон эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 3.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.8 их наяд төгрөгөөр өсчээ. Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ тайлант оны эцсийн байдлаар 0.6 их наяд төгрөгт хүрснээр өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.2 хувь боллоо. Энэ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний хамгийн бага шаардлагаас даруй 4.2 нэгж хувиар өндөр байна.

Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нийт валютын хувьд 17.4 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна. Жилийн эцсийн байдлаар нийт гадаад валютын активын хэмжээ 2.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.5 их наяд төгрөгөөр буюу 30.5 хувиар өссөн бол гадаад валютын пассивын хэмжээ 2.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 0.6 их наяд төгрөгөөр буюу 33.1 хувиар өсчээ. Гадаад валютын активын 52.9 хувийг мөнгөн хөрөнгө, 44.1 хувийг нийт зээлийн өрийн үлдэгдэл, үлдэх хэсгийн бусад активууд эзэлж байгаа бол гадаад валютын пассивын 32.8 хувийг харилцах, 32.3 хувийг хадгаламж, 15.1 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан эх

үүсвэр, 5.8 хувийг өөрийн хөрөнгө, үлдэх 14.0 хувийг бусад өглөг, эх үүсвэрийн хэмжээ эзэлж байна.

Зураг63. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт



**Тайлбар: Эрх хүлээн авагч томилогдсон банкуудын үзүүлэлтүүдийг хасч тооцсон*

Хууль, журам, эрх зүйн орчин

"Банкны тухай хууль"-ийг шинэчлэн найруулж Монгол Улсын Их Хурал 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр баталсан бөгөөд 03 дугаар сарын 31-ээс мөрдөж эхэлсэн. Шинэчлэн найруулж баталсан хуульд аливаа этгээдийн холбогдох этгээдийг илүү өргөн хүрээтэй тодорхойлж өгснөөс гадна банкны системд тулгараад байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг өгөхүйц, ирээдүйд банкны салбарын тогтвортой байдлыг хангах хэд хэдэн зохицуулалтууд бий боллоо. Тухайлбал, албадлагын арга хэмжээ авах зарчмыг нарийвчилж өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлттэй холбож өгсөн, банкны хөрөнгө оруулагчдад тавих шаардлагыг өндөрсгөж ёс зүйтэй, зөвхөн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон хөрөнгөтэй хөрөнгө оруулагч нар банкны хувь нийлүүлэгч байх, банкны холбогдох этгээдүүд болох нэг нэгдлийн доор үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдүүдээс банкинд үзүүлж байгаа нөлөө, учруулж болзошгүй эрсдэлд нэгдсэн хяналт тавьж байх зэрэг банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий зохицуулалтуудыг тусгалаа.

"Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай" хуулийн зүй бус хэрэглээг хязгаарлах үүднээс төрөөс гаргаж байгаа баталгаанд хамрагдах мөнгөн хадгаламжийн хүрээг бууруулах чиглэлээр энэхүү хуульд 2010 оны 07 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулаа. Төрөөс банкин дахь мөнгөн хадгаламжид гаргаж байгаа нийтлэг баталгаанаас хадгаламжийн даатгалын сангодог тогтолцоонд аажмаар шилжих хууль эрх зүйн орчныг

бүрдүүлэх зорилгоор “Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 640/239 тоот хамтарсан тушаалаар байгууллаа. Энэхүү ажлын хэсэг нь Монголбанк, Сангийн Яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдэж байна.

Банкны тухай хууль шинэчлэн батлагдсан, олон улсын шилдэг шинэ туршлага, хандлагыг нэвтрүүлэх, санхүүгийн хямралын үед гарч байгаа доголдол, дутагдлыг арилгах зорилгуудын хүрээнд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 тоот тушаалаар, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн, “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмж”, “Банкны зохистой засаглалын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний загвар”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 311 тоот тушаалаар тус тус баталж мөрдөж эхлээд байна.

Үүний зэрэгцээ банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг томилон ажиллуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс “Банкны хараат бус гүшүүнийг нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх журам”-ыг 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 434/113/167 тоот хамтарсан тушаалаар батлаад байгаа бөгөөд бусад журам, заавар, зөвлөмжид холбогдох өөрчлөлт, шинэчлэлийг оруулаад байна. Ингэснээр дараах шинэлэг зохицуулалтуудыг бий болголоо. Үүнд:

- Өөрийн хөрөнгө болон эрсдэлийн үзүүлэлтүүдийг илүү нарийвчлан тодорхойлсон, үйл ажиллагааны эрсдэлийн шаардлагыг шинээр нэвтрүүлсэн, хөрвөх чадварын эрсдэлийн хяналт сайжирсан
- Банкны санхүүгийн чадвар, эрсдэлийн түвшинг илүү бодитой тодорхойлдог болсон
- Нөхцлийг нь өөрчилсөн зээлийг ангилах зарчмыг нарийвчилсан,
- Холбогдох этгээдийн зээлийн хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд эрсдэлийн санг нэмж байгуулах зарчмыг бий болгосон,
- Зээлийн ангиллыг хийхдээ барьцаа хөрөнгийг харгалзаж үзэх болсон, банкууд хамтран төсөл санхүүжүүлэхийг боломжийг дэмжих зарчмыг бий болгосон,
- Банк дотооддоо эрсдэлийн үнэлгээ хийх боломжийг олгосон,
- Банкны удирдлагыг зохистой удирдлагын зарчмууд дээр үндэслэн үнэлэх зарчмыг бий болгосон.

Үүний үр дүнд хүндрэлд орсон зээлийг эртнээс тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зээлийн чанарыг зөвхөн зээлийн эргэн төлөлтийн хугацаанаас бус тухайн зээлдэгчийн бизнес болон зээлийн чанарт нөлөөлөхүйц зээлдэгчийн бусад нөхцөл байдалтай уялдуулах, банкны санхүүгийн байдлыг илүү бодитой тодорхойлох, чанаргүй активаа нуух боломжийг хаах зэрэг давуу талуудыг олгож байгаа юм. Түүнчлэн банкны удирдлагын чадвар/тогтолцоог төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, ил тод байдал, дотоод хяналт, гадаад аудит, хувь нийлүүлэгчдийн хурал гэсэн өргөн хүрээнд дүгнэдэг болсноор санхүүгийн чиглэлийн эрсдэлүүдийг удирдлагын зохистой бус тогтолцооноос үүсч болох эрсдэлүүдээр баяжуулан банкны үйл ажиллагааг цогц байдлаар үнэлэх боломжийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой байлаа.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа тэлэхийн хирээр санхүүгийн төвлөрсөн нэгдлүүд бий болж байна. Түүнчлэн банкны байгууллага оролцсон санхүүгийн нэгдэл манай орны хувьд цөөнгүй байгаа нь тухайн нэгдлийн хуулийн этгээдүүдэд нэгдсэн хяналтыг тавих тогтолцоог хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм. Энэ ч үүднээс банкны байгууллага орсон санхүүгийн нэгдэлд хэрхэн хяналт тавих тал дээр холбогдох байгууллагуудтай ажиллан судалгаа шинжилгээ, хяналт шалгалтыг хийж, олон улсын байгууллагуудаас техник туслалцааг авах хүсэлтээ тавиад байна. Монголбанкнаас “Банкны нэгдэлд хийх нэгдсэн хяналт шалгалтын журам”-ын төслийг боловсруулаад байгаа бөгөөд эхний ээлжинд нэгдлийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг оруулан тооцохоор шийдвэрлэсэн.

4.2 Банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

Хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд

Монголбанкнаас санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хямралаас шалтгаалсан банкны салбарын хэмжээнд байгаа өөрийн хөрөнгийн дутагдлыг арилгах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөр”-ийг Дэлхийн банк болон бусад Олон улсын донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр боловсруулаа. Энэхүү хөтөлбөр нь банкуудыг өөрийн хөрөнгөөр дэмжиж, банкны тухай хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангуулж, банкны системийг хүчирхэгжүүлэх зорилготой юм. Хөтөлбөрийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүдээр дамжуулан 2010 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн бариад байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг хангах үүднээс Дэлхийн банкны санхүүжилтээр банкны салбарт активын хэмжээгээр том болон дунд хэмжээнд тооцогддог 10 банкинд олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагуудаар[5] хөндлөнгийн тусгай үнэлгээг хийлгэлээ. Хөндлөнгийн тусгай үнэлгээ нь Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын холбогдох стандартуудыг баримталж хийгдсэн болно. Олон улсын валютын

[5] KPMG, Ernst&Young, PWC

сан, Дэлхийн банк хамтран Монгол Улсын “Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр”-ийг 2010 онд 2 дахь удаагаа хийлээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн салбарын байдалд шинжилгээ хийж, банкны хяналт шалгалт, бодлого зохицуулалтын чиглэлээр үнэлэлт дүгнэлт боловсруулан, цаашид банк, санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд анхаарах асуудлуудын талаар зөвлөмж өгөв.

Шинэчлэн батлагдсан “Банкны тухай хууль”-ийн 38 дугаар зүйлийн дагуу санхүүгийн тайлан болон бусад мэдээллийг нийтэд ил тод болгох шаардлагын хүрээнд Монголбанкнаас банкуудын өмчлөлийг нийтэд ил тод болгон зарласан бөгөөд банкуудын үйл ажиллагааг харилцагч нарт илүү нээлттэй болгох тал дээр ажиллаж байна.

Зээлийн эрсдэлийг бууруулах, зээлийн мэдээллийн чанар, ил тод байдал, хүртээмжийг сайжруулах зорилгоор зээлийн мэдээллийн санд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- Монголбанкны зүгээс зээлийн мэдээллийн тухай хуульд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах болон мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх талаарх зохицуулалтыг хангалттай тусгаж өгөхөд ихээхэн анхаарч, холбогдох саналаа өгч байгаа болно.
- Зээлдүүлэгч байгууллагуудыг илүү олноор зээлийн мэдээллийн санд хамруулах чиглэлээр ажиллаж байна. Тайлант онд шинээр 14 ББСБ болон ОССК зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, эдгээр байгууллагуудын мэдээллийг зээлийн мэдээллийн санд бүрэн нэгтгэж, тогтмол мэдээлэл солилцож эхэлсэн. Одоогоор зээлийн мэдээлийн санд нийт санхүүгийн салбарын зээлийн багцийн 98.7 хувьтай тэнцэхүйц мэдээлэл нэгтгэгдээд байна. Цаашид зээлдүүлэгч байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд хамруулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлж, бүх ББСБ болох ХЗХ-дыг зээлийн мэдээллийн санд хамруулах зорилготой байна.

Мөн зээлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсронгуй болгон шинэчилж, ашиглалтад оруулснаар илүү чанартай, агууламж сайтай мэдээллийг онлайн горимоор 24 цагийн туршид зээлдүүлэгч байгууллагуудтай тогтмол солилцох боломж бүрдсэн юм. Шинэ програм хангамж зээлдэгч иргэд, аж ахуй нэгжүүдийг мэдээллийн хоцролтоос үүдсэн бүх төрлийн хүндрэлгүй болгож, зээлдүүлэгч байгууллагууд чанартай мэдээллийг илүү олон сувгаар хялбар авах боломж олгож байна.

Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд

Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу нийт 9 банкинд газар дээрх ээлжит, иж бүрэн шалгалт хийж банкуудын санхүү төлбөрийн чадварыг шалган тогтоож, үнэлэлт өгөн, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтийг боловсруулан Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулан ажилласан байна. Нийт 26 удаагийн газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Иж бүрэн шалгалтаар Улсын байцаагчийн эрх үүргийн

хүрээнд активыг зохих журмын дагуу ангилаагүй, эрсдэлийн санг дутуу байгуулсан, нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаарлалтыг зөрчсөн, гадаад валютын зохистой харьцааг хангаагүй, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа хангаагүй, нягтлан бодох бүртгэлийн холбогдох заалтуудыг биелүүлээгүй, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, тайлан мэдээ буруу гаргасан, банкны удирдлагын түвшинд шаардлагатай гэрээ хэлцэл хийгдээгүй, банкны хувь нийлүүлэгчид нь хууль тогтоомж болон банкны дүрмээр олгогдсон эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаа зэрэг зөрчил дутагдалд улсын байцаагчийн акт тогтоож, холбогдох гүйлгээг, залруулгыг хийлгэх арга хэмжээ авсан болно.

Банкны шинэ хууль болон журмын шинэчилсэн заалтуудыг мөрдүүлэх, банкуудад үзүүлэх нөлөөг судлах зорилгоор 2010 оны 9 дүгээр сард зургаан банкийг сонгон хэсэгчилсэн шалгалт хийсэн. Мөн банкуудаас хууль, журмын шинэ заалтуудын хүрээнд зохистой харьцааны болон бусад үзүүлэлтүүдийг хангаж ажиллах төлөвлөгөө гаргуулан авч, хяналт тавин ажиллаж байна. Эдгээрээс гадна зарим шаардлагатай банкинд дахин шалгалт хийх, санхүүгийн байдлыг хянах ажлыг тогтмол хийж байна.

V. ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

Төв банк нь Монгол Улсын төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангах, төлбөр тооцооны системийг шинэчлэх, төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хөгжлийг дэмжих, картын төлбөр тооцоог банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулах, төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцооны систем болон банкны үйлчилгээг иргэдэд газарзүйн байршил, орлогын түвшин, цаг хугацаанаас үл хамааран түргэн шуурхай хүргэхэд анхаарч ажиллалаа. Монголбанк мобайл банкны эрх зүйн орчинг төлөвшүүлэх, мобайл банкны үйлчилгээг хөгжүүлэхэд төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хувьсан шинэчлэгдэх дэвшилтэт мобайл банкны үйлчилгээ” төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан “Үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлэх ерөнхий зөвлөмж” баримтыг монгол хэлнээ орчуулж, Монголбанкны цахим хуудсанд байршуулсан нь төлбөр тооцооны системийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чухал алхам боллоо. Үндэсний төлбөр тооцооны системийн хөгжил, түүний өөрчлөлт, шинэчлэл, өнөөгийн байдлын талаарх мэдээллийг нэгтгэж, олон улсын туршлагад өргөн дэлгэр нэвтрээд байгаа “Улаан ном”-ны жишигт нийцүүлэн Монгол Улсын төлбөр тооцооны системийн “Улаан ном”-ыг боловсруулаад байна. Энэ “Улаан ном”-ыг Олон Улсын Төлбөр Тооцооны банктай хамтран гаргах бөгөөд энэ нь манай орны төлбөр тооцооны системийн хөгжлийг олон улсад таниулан сурталчлах, олон нийтэд ил тод болгох ач холбогдолтой юм.

Банк хоорондын төлбөр тооцоо

Банк хоорондын гүйлгээний тоо болон дүнг өмнөх жилүүдтэй харьцуулан хүснэгт 14-т үзүүлэв.

Хүснэгт14. 2007- 2010 оны банк хоорондын гүйлгээний тоо, дүн[6] (улирлаар) */мянган ширхэг, их наяд төгрөг/*

	2007 он		2008 он		2009 он		2010 он	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	**378.7**	**1.4**	**499.9**	**2.4**	**502.0**	**1.7**	**693.8**	**2.2**
өсөлт (%)			*32.0*	*70.4*	*0.4*	*(29.1)*	*38.2*	*25.8*
II улирал	**482.8**	**1.8**	**633.6**	**2.8**	**715.9**	**1.8**	**908.9**	**3.0**
өсөлт (%)			*31.2*	*49.6*	*13.0*	*(35.6)*	*27,0*	*69.6*
III улирал	**413.6**	**1.8**	**494.3**	**2.6**	**626.2**	**1.9**	**801.9**	**3.4**
өсөлт (%)			*20.0*	*47.0*	*26.7*	*(24.4)*	*28.1*	*74.2*
IV улирал	**546.5**	**3.0**	**624.2**	**2.9**	**800.3**	**2.5**	**983.1**	**4.7**
өсөлт (%)			*14.2*	*(0.4)*	*28.2*	*(13.6)*	*22.8*	*86.2*
Нийт	**1821.6**	**7.9**	**2252.0**	**10.7**	**2644.4**	**7.9**	**3387.7**	**13.2**
өсөлт (%)			*23.6*	*34.4*	*17.4*	*(25.4)*	*28.1*	*66.5*

Дээрх мэдээллээс үзэхэд банк хоорондын гүйлгээний дүн өмнөх жилтэй харьцуулахад 2008 онд 34.4 хувь өссөн, 2009 онд 25.4 хувь буурсан, 2010 онд 66.5 хувиар өссөн байна. Харин банк хоорондын гүйлгээний тоо 2008 онд 23.6 хувь, 2009 онд 17.4 хувь, 2010 онд 28.1 хувиар тус тус өсчээ. Гүйлгээний тоо, дүнгийн хувьд хамгийн их гүйлгээ хийгддэг улирал нь IV улирал, хамгийн бага гүйлгээ хийгддэг улирал нь I улирал байна.

Банк хоорондын гүйлгээний тоо, дүнгийн 2007-2010 оны динамик хандлагыг зургаар үзүүллээ.

Зураг64. 2007-2010 оны банк хоорондын гүйлгээний дүн тоо, дүн (улирлаар)



[6] Банкуудаас илгээсэн гүйлгээний дүн, тоо

Банк хоорондын гүйлгээний тоо, дүн 2008 оны 4 дүгээр улирлаас 2009 оны 1 дүгээр улирлыг дуустал буурсан боловч 2009 оны 2 дугаар улирлаас эхлэн улирлын хэлбэлзлийг эс тооцвол жигд өсөлттэй байжээ.

Төлбөрийн карт

Төлбөрийн карт гаргасан банкууд "Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ"-нд 2010 онд нэгдсэнээр **"Нэг карт-Нэгдсэн сүлжээ"** үйлчилгээ бүрэн утгаараа иргэн бүрт хүрэх боломжтой болсон. 2010 оны жилийн эцсийн байдлаар **"Нэг карт-Нэгдсэн сүлжээ"** үйлчилгээнд 9 банкны 347 ширхэг АТМ төхөөрөмж, 4418 ширхэг ПОС терминал, 1576 ширхэг ПОБ терминал, 1434 банкны нэгж, 4376 картаар үйлчлэгч байгууллага холбогдон 24 цагын турш тасралтгүй төлбөр гүйцэтгэж байна. 2010 оны жилийн эцсийн байдлаар нийт 1.5 сая карт эзэмшигчдийн 1.3 их наяд төгрөгийн 14.9 сая ширхэг гүйлгээ хийгджээ. Энэ нь банк, санхүүгийн үйлчилгээ илүү хялбар, найдвартай, шуурхай болж бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ өсч, картаар үйлчлэгч аж ахуй нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ картын соёлтой хэрэглээг хэвшил болгож байгааг харуулж байна.

Хүснэгт15. Төлбөрийн картын хэрэглээ 2008-2010 он

Карт эзэмшигчдийн тоо					**Карт ашиглагчдын тоо**				
2008 он	2009 он	**2010 он**			2008 он	2009 он	**2010 он**		
		Нийт	Үүнээс: Орон нутагт	өсөлт (+), бууралт (-)			Нийт	Үүнээс: Орон нутагт	өсөлт (+), бууралт (-)
1 182 526	1 885 103	1 538 336	490942	-18%	470 773	476 230	670887	227965	35%

Карт эзэмшигчийн тоо 2008-2009 онд өссөн бол 2010 онд өмнөх жилээс 18 хувиар буурсан байна. Карт ашиглагчийн хувьд 2008-2010 он хүртэл жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа нь банкны харилцагчид бэлэн бус төлбөр тооцоог сүүлийн жилүүдэд ихээхэн ашиглах хандлагатай байгаа нь харагдаж байна. Картын хэрэглээ өргөжихийн хэрээр ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжийн тоо жил бүр нэмэгдэж байна. 2010 онд нийт төхөөрөмжийн тоо 20 хувиар өсчээ.

Хүснэгт16. Төхөөрөмжийн тоо *өсөлт (+), бууралт (–)*

Төхөөрөмж	**2 008**	**2 009**	**2 010**	**2009/2010**
ПОС	3 060	3 754	4 418	18
ПОБ	1 299	1 186	1 576	33
АТМ	189	292	347	19

Импринтер	470	417	412	-1
НИЙТ	**5 018**	**5 649**	**6 753**	**20**

ПОС, ПОБ, АТМ–аар хийгдсэн гүйлгээний тоо, дүнг хүснэгт 17-д үзүүлэв. Хүснэгтээс үзэхэд, ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 2010 онд өмнөх жилээс 170 хувиар өссөн байгаа нь төлбөрийн картын хэрэглэгчид үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхдээ картаар төлбөр тооцоо хийх хандалага нэмэгдэж, картын хэрэглээний зах зээл тэлснийг харуулж байна. Харин ПОБ терминал буюу банкинд дээр байршиж байгаа тоног, төхөөрөмжөөр үйлчлүүлсэн дүнг авч үзвэл 2010 онд өмнөх оныхоос 12 хувиар, гүйлгээний тоо 32 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт17. ПОС, ПОБ, АТМ-ээр хийгдсэн гүйлгээ[7], (сая ширхэг, тэрбум төгрөг)

	2008	**2009**	**2010**	**2009/ 2010** *Өсөлт (+) Бууралт(-)*
ПОС Дүн	**53.2**	**51.2**	**138.1**	**170**
Тоо	*0.7*	*1.0*	*1.5*	*52*
ПОБ Дүн	**261.4**	**232.5**	**205.7**	**-12**
Тоо	*2.2*	*1.7*	*1.2*	*-32*
АТМ Дүн	**170.7**	**535.1**	**906.4**	**69.0**
Тоо	*5.3*	*8.7*	*12.2*	*41*
Нийт Дүн	**485.3**	**818.8**	**1250.2**	**53**
Тоо	*8.2*	*11.4*	*14.9*	*31*

АТМ төхөөрөмжөөр 2010 онд нийт 906 тэрбум төгрөгийн 12.2 сая ширхэг гүйлгээ хийгдсэн байна.

Зураг65. 2008-2010 онд картаар хийгдсэн гүйлгээний дүн

[7] Банкуудын хүлээн авсан картын гүйлгээний дүн, тоо



Зургаас үзэхэд ПОС терминалаар хийгдэж байгаа гүйлгээний дүн жил бүр өсч, 2010 онд 138.1тэрбум төгрөг, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн 906.4 тэрбум төгрөгт хүрчээ. АТМ төхөөрөмжөөр хийсэн гүйлгээний дүн өмнөх оноос 69 хувиар өссөн байна. Харин ПОБ терминалаар үйлчлүүлэгчдийн тоо буурах хандлагатай буюу 2010 онд хийгдсэн гүйлгээ нь өмнөх жилээс 26.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

VI. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүтэц зохион байгуулалтын талаар:

Төв банк нь 7 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна. Банкны сургалтын төв Монголбанкны удирдлагад ажиллаж байна. Монголбанкинд нийт 391 ажилтан ажиллаж байгаагийн 52.2 хувь нь эрэгтэй, 47.8 хувь нь эмэгтэй ажилтан байна. Нийт ажилтнуудын 71 хувь нь Төв аппаратад ажиллаж байна. Нийт ажилтнуудын 76 хувь нь эдийн засагч, нягтлан бодогч, эрх зүйч, мэдээллийн технологийн инженерийн мэргэжилтэй боловсон хүчин байна.

Зураг66. Ажилтнуудын насны ангилал



Ажилтнуудын мэргэжил мэдлэгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, сурч боловсрох эрхийг хангаж олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудын Засгийн газрын шугамаар АНУ, Австрали, Япон, Европ улсад мэргэжил дээшлүүлэх магистрийн сургалтад 2010 онд 8 ажилтан хамрагдаж байна. Гадаад оронд зохион байгуулагдсан богино хугацааны 99 сургалтад нийт 90 ажилтан хамрагдсан байна.

Монголбанк, Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбоо (ЗӨАТБХ), Японы төв банктай хамтран "Хөрөнгийн үнийн өсөлт: Мөнгөний бодлогод үзүүлэх нөлөө ба сорилт" сэдэвт семинарыг Улаанбаатар хотод 2010 оны 7 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэ үеэр ЗӨАТБХ, Тайландын Төв банк, Япон, Солонгосын Төв банк туршлагаа хуваалцлаа. Семинарт 12 орны 28 зочид төлөөлөгчид, Монголбанкны 10 ажилтан болон холбогдох албан тушаалтнууд оролцсон.

Английн төв банкны Төв банк судлалын төвөөс Монголбанктай хамтран "Мөнгөний бодлого ба түүний үйл ажиллагаа: хямралын сургамж" сэдэвт семинарыг Улаанбаатар хотод 2010 оны 8 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг семинарт Монголбанк, СЯ, ҮХШХ, СЗХ, МУ-ын Ерөнхийлөгчийн ТГ зэрэг байгууллагуудаас нийт 32 хүн оролцсон.

Ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааны талаар:
Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу 2010 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн төрийн, төсвийн байгууллагуудын ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан төрийн болон ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудын цалин хөлсний талаар нэгдсэн судалгаа хийж, судалгааны дүнг Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажилтнуудын цалинг нийтэд нь 30 хувиар нэмэгдүүлсэн.

Ажилтнуудыг сургаж, мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, ахуй хангамж, орон сууцны нөхцлийг сайжруулах арга хэмжээг батлагдсан төсөв хөрөнгөтэй уялдуулан тухай бүр шийдвэрлэхийн зэрэгцээ ажилтнуудын ажлын ачааллыг жигдрүүлэх, ажлын цагийн ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх талаар газар, албадтай хамтран ажиллаж байна.

Мэдээлэл технологийн талаар

Мэдээллийн технологийн газар нь 2010 онд чиг үүргийнхээ дагуу Монголбанкны үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн техник, технологи, програм хангамжийн системүүдийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангаж, аливаа саатал гаргалгүй ажиллалаа. Мөн түүнчлэн мэдээллийн технологийн сүүлийн үеийн шинэчлэлийг нэвтрүүлэх ажлууд хийлээ. 2010 онд Монголбанкинд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдэд илэрч буй алдааг судлах ажлыг зохион байгуулж үр

дүнд дүгнэлт гарган, тэдгээр илэрсэн алдаа, дутагдлыг арилгав. Тухайн жилд хийсэн ажлуудаас товч дурдъя.

- Гадаад валютын арилжааны, Гадаадын үнэт цаасны бүртгэлийн, Гадаад валютын нөөцийн урсгал, өгөөжийг тооцох, Орлого, зардлын бүртгэлийн зэрэг програм хангамжуудыг өөрсдийн програм зохиогчдын хүчээр шинээр боловсруулж, ашиглалтад оруулав.
- Япон улсын ЖАЙКА байгууллагын техник, тусламжаар 2010 онд ашиглалтад орсон Тайлан бүртгэлийн системд шаардлагатай өөрчлөлтийг оруулав.
- Банк хоорондын мөнгөний захын үйл ажиллагаанд ашиглагддаг ТБҮЦ-ны програм хангамжийг өргөтгөн, шинэ функцуудыг боловсруулав.
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжид илэрч байсан алдаа дутагдлуудыг засаж, шинэ тайлангуудыг боловсруулав.
- Монголбанкны дотоод сүлжээний аюулгүй байдлыг сайжруулж, хяналтын системийг нэвтрүүлэн хурд, хүчин чадлыг нэмэгдүүлэв.

Банкны хууль тогтоомжийн хөгжил

Банкны тухай хууль

Улсын Их Хурлын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 2008 оны 31 дүгээр тогтоолын хавсралтын 2.1-д “Банкны салбарын тогтвортой байдлыг хамгаалсан бодлого явуулна” гэж, Улсын Их Хурлын “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” 2009 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэн тэргүүнд боловсруулж, батлуулахаар тус тус тусгагдсны дагуу “Банкны тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдсан.

Энэ хуулиар хуулийн нэр томъёог шинэчлэх, тухайлбал, холбогдох этгээд, банкны нэгдэл, нэгдсэн хяналт шалгалт, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэсэн ойлголтыг шинээр хуульчилсан. Мөн Банк хараат болон охин компани байгуулж болох ба эдгээр компани нь Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулах, банкны харилцагчийн мэдээллийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр бусдад гаргаж өгөх, банк үүсгэн байгуулахад тавигдах шаардлагыг нэмсэн.

Банкны зохистой удирдлагыг бэхжүүлэх зорилгоор хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын харилцааг нарийвчилан зохицуулсан ба төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнтэй байх, түүний шалгуурыг тодорхой оруулсан. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг эдийн засгийн байдал, мөнгөний ханшийн өөрчлөлт,

банкны төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк тогтоохоор зохицуулсан.

Банкны хувьцааг эзэмших зөвшөөрлийг Монголбанкнаас олгохдоо нөлөө бүхий болон нөлөө бүхий бус хувьцаа эзэмшигчдийн ялгавартай зохицуулж, банкны хувьцааг иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглосон, банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглосон зохицуулалт орлоо.

Банкны санхүүгийн тайлан бүртгэлийн тогтолцооны шалгуурыг боловсронгуй болгож, санхүүгийн тайлан, холбогдох этгээд болон эрх бүхий этгээд болон бусад мэдээллийг нийтэд мэдээлэх замаар банкны эрсдэлийг бууруулах, банкны нэгдлийн оролцогчийн үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийхдээ шаардлагатай гэж үзвэл санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт шалгалт хийхээр хуульчиллаа.

Банкинд хүлээлгэх албадлагын арга хэмжээг зөрчлийн шинж байдлыг харгалзан дэс дараалалтай авах, өөрийн хөрөнгийн аль нэг шаардлагыг 80 хүртэл хувиар хангаагүй банкинд авах албадлагын арга хэмжээг шинээр оруулсан ба өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг ханган ажиллах төлөвлөгөө, түүнд тавих шаардлага, банкинд онцгой дэглэм тогтоох үе дэх банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсвийн санхүүжилт шаардлагатай гэж үзвэл Монголбанк уг төлөвлөгөөг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тав хоногийн дотор батлах, банкны эрх хүлээн авах үе дэх төлбөр барагдуулах дараалал болон хууль тогтоомж зөрчсөн этгээдэд ногдуулах хариуцлагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан зохицуулсан болно.

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль 1996 онд батлагдан хэрэглэснээс хойш түүнд 1998, 1999, 2001, 2003 онд нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна. Улсын Их Хурлаас Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан билээ. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс бүрдэх ба зөвлөл нь санхүүгийн асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд хүргүүлж болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл гаргасан шийдвэр, зөвлөмж болон дүгнэлтээ нийтэд мэдээлэхээр хуульчилсан.

Мөн Монголбанк санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулах, мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг тогтоох, санхүүгийн тайлангаа олон улсын нягтлан бодох бүртгэлийн жишгийн дагуу хөтөлж бэлтгэх, мөнгөний болон төсвийн бодлогын хоорондын уялдаа буюу Монголбанк ба Засгийн газрын хоорондын харилцааг нийтэд ил тод болгох, Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд Засгийн газа р үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэхээр нэмэлт орсон.

Банкны заавал байлгах нөөцийн хэмжээг дээд хязгаарт нь багтаан Монголбанк уян хатан тогтоох, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хугацаа, төрлөөс хамааруулан ялгаатай тогтоох, банкны хүлээн зөвшөөрөх активын жагсаалтыг Монголбанк баталж, нийтэд ил тод мэдээлэх, албадлагын арга хэмжээний хүрээнд онцгой дэглэм тогтоосон үед санхүү, банкны тогтолцоог эрсдэлээс хамгаалах зорилгоор зээл олгох зэрэг өөрчлөлт орлоо.

Мөн Хяналт шалгалтын хувьд банкны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамжид нэвтрэх, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь удирдах болон эрх бүхий албан тушаалд ажилладаг банкинд хяналт шалгалт хийхийг хянан шалгагчид хориглосон, Монголбанкны Зөвлөлийн гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн дотор банкны удирдах албан тушаалд ажиллахыг хориглосон зохицуулалт орлоо.

МОНГОЛБАНКНААС 2010 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

Д/д	Огноо	Дугаар	Нэр	Агуулга
1	2010.04.13	210	Журамд өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан “Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-д Төв банкны үнэт цаасны арилжаанд хэрэглэх тогтмол хүүний дээд, доод хязгаарыг тогтоох болон арилжаа нь хүүгээр өрсөлдөх зарчмын талаар тусгасан. Түүнчлэн Монголбанкны бодлогын хүүгийн талаар зохицуулсан.
2	2010.04.20	232	Журамд өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан “Төв банкны үнэт цаасны арилжааны журам”-д худалдан авах Төв банкны үнэт цаасны хэмжээ, заавал байлгах нөөцийн хэмжээ болон Төв банкны үнэт цаасыг худалдан авах хүүгийн саналын талаар тусгасан.
3	2010.05.04	266/97/62	Дүрэм батлах тухай	Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм, ажлын албаны бүтэц, орон тоо, зохион байгуулалтыг баталсан.
4	2010.05.06	278	Журам батлах тухай	“Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалагчид мэдээлэл өгөх журам”-аар үл хөдлөх хөрөнгө худалдан авах, барилга байгууламж, орон сууц барих, засан сайжруулах зорилгоор тухайн үл хөдлөх хөрөнгийг барьцаалж зээл авах зэрэг үйл ажиллагааг зохицуулна.
5	2010.05.12	117/284	Журам батлах тухай	“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор банкнаас эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх журам”-аар мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээр шалгагдаж буй хувь хүн болон хуулийн этгээдийн данс, гүйлгээ зэрэг холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад хэрхэн шилжүүлэх талаар журамлав.
6	2010.05.24	305	Маягт батлах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007/07/02-ны өдрийн 313 дугаар тушаалаар батлагдсан “Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 3.1.3 дахь заалтын “Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай” тайлангийн маягтыг баталсан.
7	2010.05.26	311	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006/12/21-ний өдрийн 594 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам” болгон өөрчлөв. Мөн банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх зөвлөмж, Мэдээллийн технологийн хяналт шалгалтын зөвлөмж болон Банкуудын зохистой удирдлагын хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний зааврыг баталсан.
8	2010.06.16	365	Журамд өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009/08/06-ны өдрийн 440 дүгээр тушаалаар батлагдсан “Төлбөрийн картын журам”-д банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний төлбөр тооцоог хийгдэж буй гүйлгээнээс үл хамааран банк хоорондын бага дүнтэй гүйлгээний журамд зааснаар гүйцэтгэхээр зохицуулав.
9	2010.07.20	434/113/167	Журам батлах тухай	Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, журам”-ыг баталсан. Энэхүү журмаар банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, түүний эрх, үүрэг,

				хараат бус гишүүнд хэрхэн нэр дэвшүүлэх, түүнийг сонгон шалгаруулах хороог байгуулах, сонгох, чөлөөлөх, мөн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тодорхой тусгасан.
10	2010.07.28	447	Заавар батлах тухай	“Банкны хувийн хэрэг хөтлөх, шилжүүлэх, танилцуулах заавар”-аар банкны үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтыг хэрэгжүүлэх, санхүүгийн тайлан мэдээ, банкны талаарх албан баримт бичиг, судалгааны материал зэргийг цуглуулан хувийн хэргийг бүрдүүлж, үнэн зөв, бүрэн дүүрэн, системчлэн хөтлөх, хувийн хэрэг шилжүүлэх зэргийг зохицуулсан.
11	2010.07.30	460	Журам шинэчлэн батлах тухай	“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-аар Банкны тухай хуулийн 16.1.2 дахь заалтад заасан шаардлагыг банк хэрхэн хангаж байгааг тооцох, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгаад хяналт тавих арга хэмжээг зохицуулсан.
12	2010.08.03	464	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 444 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь шалгалт хийж, үнэлгээ, дүгнэлт өгөх журам”-д банкны зохистой засаглалын дотоод үнэлгээний талаар нэмэлт орсон.
13	2010.08.11	475/182	Журам шинэчлэн батлах тухай	Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар “Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан.
14	2010.11.19	647	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дуудлага худалдааны хаалтын ханшийг хүргүүлэх хугацааны талаар “Гадаад валютын дуудлага худалдааны журам”-д нэмэлт орсон.
15	2010.11.22	674	“Дотоод банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах журам”, “Дотоод банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах заавар”-ыг батлах тухай	Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах үйл ажиллагааг зохицуулах, уг үйл ажиллагаанд оролцогч этгээд, нэгж тус бүрт тавигдах шаардлага болон тус бүрийн хийх ажлыг тодорхойлох, харилцан хяналт тавих нөхцлийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг зохицуулсан.
16	2010.12.03	699	Журам, зааварт өөрчлөлт оруулах тухай	“Төгрөгийн гадаад валюттай харьцах албан ханш тооцох заавар”, “Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш тооцох журам”-д ам.долларын арилжааны мэдээг ирүүлэх хугацааг өөрчлөн тусгасан.
17	2010.12.03	700	Журам, зааварт өөрчлөлт оруулах тухай	“Гадаад валютын дуудлага худалдааны журам”, “Гадаад валютын дуудлага худалдаа явуулах заавар”-т банкууд худалдах, худалдан авах саналаа “Гадаад валютын цахим арилжааны систем”-д оруулах тухай болон саналаа ирүүлэх хугацааны талаар нэмэлт өөрчлөлт орсон. Мөн “Гүйлгээний шийдвэрийн маягт”-ыг шинэчлэн баталсан.
18	2010.12.24	730	“Валютын своп, форвард хэлцлийн гэрээ”, “Валютын своп, форвард хэлцлийн заавар”-ыг батлах тухай	Төв банкнаас дотоодын банктай төгрөг, ам.долларын своп/форвард хэлцлийг хийж, төгрөг болон ам, долларын богино хугацаат эх үүсвэр нийлүүлэх, татах, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах хэрэгсэл бий болгох үйл ажиллагаанд оролцогч этгээд, нэгж тус бүрт тавигдах шаардлага болон бусад харилцааг зохицуулсан.
19	2010.12.27	735	Журамд өөрчлөлт оруулах тухай	“Гадаад валютын дуудлага худалдааны журам”-ын 5 дугаар хавсралт /Гадаад валютын өдрийн дуудлага худалдаа/-ыг өөрчилсөн.